

ГАР УГААХ

Тодорхойлолт

- Өвчин үүсгэгч бичил биетнийг устгах зорилгоор гар угаана.

Зорилго

- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх

Хамрах хүрээ

- Сувилагч, эмч, эрүүл мэндийн байгууллагын ажилтан
- Резидэнт эмч, оюутан

Заалт

- Үйлчлүүлэгчид хүрэхийн өмнө
- Үйлчлүүлэгчид хүрсний дараа
- Ариун ажилбар гүйцэтгэхийн өмнө
- Биологийн шингэнд хүрсний дараа
- Үйлчлүүлэгчийн эргэн тойрон, орчны эд зүйлст хүрсний дараа
- Бие зассаны дараа
- Гар нүдэнд харагдахуйц бохир үед
- Бээлий тайлсны дараа
- Короновирус, ротавирус, гепатитийн A вирус зэрэг бүрхүүлгүй вирус болон C.difficile, спортой бактерийн халдварын сэжигтэй болон батлагдсан үйлчлүүлэгчид тусламж үзүүлэх

Эсрэг заалт

- Байхгүй

Хэрэглэгдэх зүйлс

- Халуун, хүйтэн ус бүхий угаалтуур
- Гарын шингэн саван
- Гар арчих зориулалтын нэг удаагийн цаасан алчуур
- Хөл даруулаар онгойдог хогийн сав
- Гар арчих цаасан сальфетка

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө

- Хэрэглэгдэх зүйлсийг бүрэн эсэхийг шалгана.
- Гарын хумс 0.2 см-с урт биш, будаггүй байна.
- Хиймэл хумсгүй, бөгж, бугуйвч, бугуйн цаггүй байна.
- Ханцууй богино эсвэл хойш эргүүлэн шуусан байх

Үйлдлийн явц

- Усны хэмийг тохируулна.
- Гарын алга, бугуй хүртэл усаар норгоно.
- Алганы хонхорт шингэн саванг хангалттай хэмжээгээр авна.
- Хоёр гарын алгаа хооронд нь үрж саванг хөөсрүүлнэ.
- Хоёр гарын хуруунуудын завсрыг угаана.
- Нэг гарын алгаар нөгөө гарын алга, ар талыг угаана.
- Хурууг үеэр нугалж нөгөө гарын алган дотор хурууны үзүүр, хумс, үений хэсгийг угаана.
- Алганы хонхорыг нөгөө гарын хурууны үзүүр хэсэгтэй хооронд нь угаана.
- Эрхий хурууг нөгөө гарын алган дотроо эргэлдүүлэх хөдөлгөөнөөр угаана.
- Гарын бугуйг угаана.
- Ургсал усаар зайлж, савангаа арилгана.
- Гар тань таны тохойноос өндөрт байна.
- Дээрх үйлдлүүдийг 1 минутаас багагүй хугацаанд 3-с цөөнгүй удаа давтан хийнэ.
- Гарыг нэг удаагийн цаасан алчуураар гарын үзүүрээс эхлэн бугуй хүртэл арчина.
- Крантаа цаасан алчуураар жийрэглэж хаана.
- Хэрэглэсэн цаасан алчуурыг хөл даруулаар онгойдог хогийн саванд хаяна.

Үйлдлийн дараа

- Гар угаасны дараа орчны гадаргуу, хийх ажилбараас бусад зүйлд хүрч гарваа бохирдуулахаас сэргийлнэ.

Анхаарах зүйлс

- Эрүүл мэндийн байгууллага нь гар угаах нөхцлийг бүрдүүлсэн байна.
- Угаалтуур бүрт гарын шингэн саван, нэг удаагийн цаасан алчуур, хогийн сав байна.
- Гар угаах дараалал, санамж бүхий зурагт хуудсыг байрлуулна.

- Гарын хумс будагтай, хиймэл хумстай байхыг зөвшөөрөхгүй.
- Давтан арчдаг даавуун алчуур, гар хатаагч сэнс хэрэглэхгүй.
- Эрүүл мэндийн байгууллагын ажилтныг гар угаах мэдлэг, дадал олгох сургалтад жилд 1-с доошгүй удаа хамруулна.
- Эрүүл мэндийн байгууллагын ажилтан зөв аргачлалаар гар угааж буй эсэхэд тасаг, нэгжийн эрхлэгч, ахлах сувилагч, халдварт судлаач эмч хяналт тавина.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй хүмүүс, ялангуяа үйлчлүүлэгчдэд эмчилгээ, асаргаа, сувилгаа хийдэг бүх (эмч, сувилагч, эх баригч, лаборант, бага эмч, гал тогооны ажилчид, туслах ажилчид) мэргэжилтнүүд

Үйлдлийн гүйцэтгэлд тавигч

- Сувилагч, ахлах сувилагч, эх баригч, бага эмч, эмч, ХСХ-ын баг

ГАР ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ

Тодорхойлолт

- Гарыг ус, саван ашиглан угааснаас илүүтэйгээр халдвартгүйжүүлэх шаардлагатай үед спиртэн суурьтай гар халдвартгүйжүүлэх уусмалаар халдвартгүйжүүлнэ.

Зорилго

- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх

Хамрах хүрээ

- Эрүүл мэндийн байгууллагын ажилтан
- Дадлагажигч эмч, оюутан

Заалт

- Үйлчлүүлэгчид хүрэхийн өмнө
- Үйлчлүүлэгчид хүрсний дараа
- Ариун ажилбар гүйцэтгэхийн өмнө
- Биологийн шингэнд хүрсний дараа
- Үйлчлүүлэгчийн эргэн тойрон, орчны эд зүйлст хүрсний дараа
- Гар нүдэнд харагдахуйц бохирдоогүй үед
- Бээлий тайлсны дараа

Эсрэг заалт

- Гарт ил шархтай үед

Хэрэглэгдэх зүйлс

- 70-80% спиртийн агууламжтай, арьс чийгшүүлэх бодис бүхий гар халдвартгүйжүүлэх уусмал

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө

- Хэрэглэгдэх зүйлсийг бүрэн эсэхийг шалгана.
- Гарын хумс 0.2 см-с урт биш, будагүй байна.
- Хиймэл хумсгүй, бөгж, бугуйвч, бугуйн цаггүй байна.
- Ханцууй богино эсвэл хойш эргүүлэн шуусан байх

Үйлдлийн явц

- Халдвартгүйжүүлэх бодисоос алганы хонхорт хангалттай хэмжээгээр авна.
- Хоёр гарын алгаа хооронд нь угаана.
- Хуруунуудын завсрыйг угаана.
- Нэг гарын алгаар нөгөө гарын алга, ар талыг угаана.
- Хурууг үеэр нугалж нөгөө гарын алган дотор хурууны үзүүр, хумс, үений хэсгийг угаана.
- Алганы хонхорыг нөгөө гарын хурууны үзүүр хэсэгтэй хооронд нь угаана.
- Эрхий хурууг нөгөө гарын алган дотроо эргэлдүүлэх хөдөлгөөнөөр угаана.
- Гарын бугуйг угаана.
- Дээрх үйлдлүүдийг 30 секундээс багагүй хугацаанд гүйцэтгэнэ (Гар хуурай болтол).

Үйлдлийн дараа

- Гараа халдвартгүйжүүлсний дараа орчны гадаргуу, хийх ажилбараас бусад зүйлд хүрч гарaa бохирдуулахаас сэргийлнэ.
- Гар халдвартгүйжүүлэх уусмал гар бүрэн шингэсэн байна.

Анхаарах зүйлс:

- Гарын хумс будагтай, хиймэл хумстай байхыг зөвшөөрөхгүй.
- Эрүүл мэндийн байгууллагын ажилтныг гар халдвартгүйжүүлэх мэдлэг, дадал олгох сургалтад жилд 1-с доошгүй удаа хамруулна.
- Эрүүл мэндийн байгууллагын ажилтан зөв аргачлалаар гар халдвартгүйжүүлж буй эсэхэд тасаг, нэгжийн эрхлэгч, ахлах сувилагч хяналт тавина.
- Гар халдвартгүйжүүлэх бодисыг ашиглаж эхлэхдээ нээсэн огноо, савлаж хэрэглэдэг бол дахин савласан огноог тэмдэглэнэ.
- Гар халдвартгүйжүүлэх бүтээгдэхүүн арьсыг хэт хуурайшуулах, харшил өгч байгаа тохиолдолд тасаг нэгжийн эрхлэгч, тархвар судлаач, халдварын сэргийлэлт, хяналтын ажилтан, алба, багт мэдэгдэнэ.
- Гар халдвартгүйжүүлэх уусмалын найрлагад харшилтай хүмүүс анхаарах

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй хүмүүс, ялангуяа үйлчлүүлэгчид эмчилгээ, асаргаа, сувилгаа хийдэг бүх (эмч, сувилагч, лаборант, бага эмч, гал тогооны ажилчид, туслах ажилчид) мэргэжилтнүүд

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, ахлах сувилагч, бага эмч, эмч, ХСХ-ийн баг

БЭЭЛИЙ ӨМСӨХ, ТАЙЛАХ АРГА

Тодорхойлолт

- Бээлий нь үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн байгууллагын ажилтныг бичил биетнээр бохирдооос хамгаалдаг.

Зорилго

- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх

Хамрах хүрээ

- Эрүүл мэндийн байгууллагын ажилтан
- Дадлагажигч эмч, оюутан

Заалт

- Эмнэлгийн, халдвартай, ариун бус нөхцөлд сувилахуйн гардан ажилбарыг хийхийн өмнө халдвараас өөрийгөө хамгаалах, бусдад халдвар дамжуулахаас урьдчилан сэргийлэх тохиолдол бүрт

Эсрэг заалт

- Ариун бээлийний хугацаа дууссан
- Бүрэн бүтэн байдал алдагдсан үед

Хэрэглэгдэх зүйлс

- Гарын хэмжээнд тохирсон бээлий
- Аюултай хог хаягдлын уут

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө

- Хэрэглэгдэх зүйлсийг бүрэн эсэхийг шалгана.
- Стандартын дагуу гарын эрүүл ахуй сахисан байна.

Үйлдлийн явц

- Гарын хэмжээнд тохирсон бээлийг сонгон авна.
- Бээлийний бүрэн бүтэн эсэхийг шалгана.
- **Бээлийний бугуйн хэсгээс барьж баруун гараар зүүн гарг өмсгөнө.**
- **Баруун гарг өмсөх бээлийг авч өмснө.**
- Хоёр бээлийний бугуйн хэсгээс гүйцэд татаж засна.
- Ажилбар гүйцэтгэсэний дараа зүүн гараар баруун гарын бээлийний бугуйн хэсгийн гадна талаас барьж, дотор талыг гадагш эргүүлэн тайлна.
- Зүүн гарын бээлийний дотор талд баруун гарын хурууг оруулан доош татан хумьж барьсан бээлийг дотор талд нь хийсэн байдлаар тайлна.
- Тайлсан бээлийг зүүн гартаа хумьж базна.
- Тайлсан бээлийг шар уутанд хаяна.

Үйлдлийн дараа

- Ажилбар дууссаны дараа бээлийгээ тайлж, гарaa сайтар савандаж угааж, халдвартгүйтгэнэ.

Анхаарах зүйлс:

- Нэг үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлж байхдаа халдвартай хэсгээс халдвартгүй хэсэг рүү дамжихдаа, үйлчлүүлэгчид хүрсний дараа, халдвартай хэсэгт хүрэлцсэний дараа, цэвэр орчинд ажиллахын өмнө бээлийгээ солих буюу тайлах шаардлагатай.
- Гепатит В, С ба ХДХВ-ын халдвартын тархалт хамгийн өндөр байдаг орнуудад, 30 минутаас дээш хугацаанд үргэлжлэх хагалгаанд орохдоо, их хэмжээний цус, биеийн шингэнтэй харилцах тохиолдолд, өндөр эрсдэлтэй гэмтлийн мэс ажилбар хийхдээ бээлийг давхарлан өмсөх нь зүйтэй.
- Буруу хадгалсан, хугацаа дууссан, урагдаж цоорсон бээлийг хэрэглэж болохгүй.
- Цус, биологийн шингэн зэрэг халдвартай материалтай ажиллахдаа заавал нэг удаагийн бээлий хэрэглэн эмнэлгийн хог хаягдлын менежментийн зааврын дагуу цуглуулан устгалд өгнө.
- Хэрвээ бээлий халдвартай материалыар бохирдсон, үйлдлийн явцад цоорч урагдсан тохиолдолд тэр даруй бээлийг журмын дагуу тайлан устгалд өгч, гарaa сайтар угааж ариун бээлий өмснө.
- Бээлийтэй гараар нүд, хамар, амандаа хүрэх, лабораториос гарахыг хориглоно.
- Бээлийг тайлах явцад нүцгэн гараар бээлийний гадна талд хүрэхгүй.

Үйлдлийг гардан гүйцэтгэг

- Эмнэлгийн халдвартай, ариун бус нөхцөлд үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагын ажилтан

Үйлдлийн гүйцэтгэлд тавигч

- Сувилагч, эх баригч, ахлах сувилагч, бага эмч, эмч

БИЕИЙН ХАЛУУН ХЭМЖИХ

Тодорхойлолт

- Хүн ба амьтны бие махбодод бодисын солилцооны үр дүнд энерги үүсч улмаар дулаан бий болдог. Хүний биеийн дулаан үүсэлт болон дулаан алдалтын зөрүүг биеийн халуун гэнэ.

Зорилго

- Эмчлүүлэгчийн биеийн халууны хэмжээ, халууны өөрчлөлт, давтамж зэргийг тодорхой хугацаанд хянаж, халууралтын байдлыг зураглалаар гаргах

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Үйлчлүүлэгч (амбулаторид) болон эмчлүүлэгчийн (Хэвтэн эмчлүүлэх тасагт) амин үзүүлэлтийг хянах
- Биеийн халууны өөрчлөлт, давтамжинд үнэлгээ өгөх

Эсрэг заалт:

- Байхгүй

Анхаарах зүйлс

- Халууны шилийг халдвартгүйжүүлсэн эсэх, бүрэн бүтэн байдлыг заавал шалгана.
- Эмчлүүлэгчийн халууныг хэмжихээс 30 минутын өмнө хэт халуун, хүйтэн хоол унд хэрэглэсэн эсэхийг асууна.
- Тамхи татаагүй байна.
- Хүүхэд, сэтгэцийн өөрчлөлттэй, хамраар амьсгалах боломжгүй, амьсгаадаж байгаа үйлчлүүлэгчийн халууныг амны хөндийд хэмжихгүй.
- Шулуун гэдсэнд халуун үзэх тохиолдолд халууны шилийг заавал зориулалтын тосоор тослоно.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Туслах сувилагч, сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

Суганы хонхорт биеийн халуун хэмжих

Хэрэглэгдэх зүйлс:

1. Зориулалтын халууны шил
2. Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
1. Гар хадваргүйжүүлэх уусмал
2. Цаасан сальфетик
3. Сувилгааны түүх
4. Хар өнгийн бал, үзэг, шугам
5. Хог хаягдлын уут

Хийх үйлдлийн дараалал:

Үйлдлийн өмнө

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйөч дээрх мэдээлэлтэй тулгах).
- Үйлдлийн өмнө эмчлүүлэгчээс халууныг хэмжихээс 30 минутын өмнө хэт халуун, хүйтэн хоол унд хэрэглэсэн эсэх, шатаар өгсөх гэх мэт ачаалал авсан зэргийг асууна.

Үйлдлийн явцад

- Хийх гэж буй үйлдлээ танилцуулан зөвшөөрөл авна.
- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Эмчлүүлэгчээ зөв байрлуулна.
- Халууны шилний бүрэн бүтэн байдлыг шалгаж халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлгөөр арчиж халдвартгүйжүүлнэ.
- Эмчлүүлэгчийн халууныг хэмжих биеийн хэсгийг ил гаргаж, чийгтэй тохиолдолд цаасан сальфеткаар хуурай болтол арчина.
- Халууны шилний асаах товчлуурыг дарж асаан $L^{\circ}C$ тэмдэг гарахад суганы хонхорт хавчуулж хавчуулсан гарыг тохойгоор нь нугалуулан, нөгөө гарын тохойн хэсгээс

бариулна. Хэвтэж байгаа бол хэмжиж буй талын гарыг цээжин хэсэгт нугалуулан байрлуулна.

- Халууны шилний дохио дуугарахад халууны шилийг авч заалтыг харна.

Үйлдлийн дараа:

- Халууны шилийг халдвартгүйжүүлнэ.
- Хэрэглэсэн зүйлсээ хураана.
- Хог хаягдлыг зааврын ангилан устгана.
- Гараа угаана, халдвартгүйжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийн хуудсанд халууныг тэмдэглэнэ.
- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэн тохирох арга хэмжээг авна.

Амны хөндийд биеийн халуун хэмжих

Хэрэглэгдэх зүйлс:

1. Зориулалтын халууны шил
2. Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
3. Гар халдвартгүйжүүлэх уусмал
4. Цаасан сальфетик
5. Сувилгааны түүх
6. Хар өнгийн бал, үзэг, шугам
7. Хог хаягдлын уут

Хийх үйлдлийн дараалал:

Үйлдлийн өмнө

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын буруу чадварыг дээрх мэдээлэлтэй тулгах).
- Үйлдлийн өмнө эмчлүүлэгчээс халууныг хэмжихээс 30 минутын өмнө хэт халуун, хүйтэн хоол унд хэрэглэсэн эсэх, шатаар өгсөх гэх мэт ачаалал авсан зэргийг асууна.

Үйлдлийн явцад

- Эмчлүүлэгчийг бэлтгэж тохиромжтой байрлалд байрлуулна.
- Халууны шилний асаах товчлуурыг дарж асаан L°C тэмдэг гаргана.
- Эмчлүүлэгчийн амыг ангайлган заалттай хэсгийг доош нь харуулж хэлэн доор байрлуулан амыг жимиийлгэнэ.
- Халууны шилний дохио дуугарахад халууны шилийг авч заалтыг харна.

Үйлдлийн дараа

- Халууны шилийг халдвартгүйжүүлнэ.
- Хэрэглэсэн зүйлсээ хураана.
- Хог хаягдлыг зааврын ангилан хаяна.
- Гараа угаана/ халдвартгүйжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийн хуудсанд халууныг тэмдэглэнэ.
- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэн тохирох арга хэмжээг авна.

Чихэнд биеийн халуун хэмжих

Хэрэглэгдэх зүйлс:

1. Зориулалтын халууны шил
2. Нэг удаагийн шүүлтүүр
3. Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
4. Гар халдвартгүйжүүлэх уусмал
5. Сувилгааны түүх
6. Хар өнгийн бал, үзэг, шугам
7. Хог хаягдлын уут

Хийх үйлдлийн дараалал:

Үйлдлийн өмнө

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.

- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (ЭМС-ийн 2022.07.04-ны A/352 тоот тушаалын дагуу овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйвч дээрх мэдээлэлтэй тулгах)
- Үйлдлийн өмнө эмчлүүлэгчээс халууныг хэмжихээс 30 минутын өмнө хэт халуун, хүйтэн хоол унд хэрэглэсэн эсэх, шатаар өгсөх гэх мэт хэт ачаалал авсан зэргийг асууна.

Үйлдлийн явцад

- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Эмчлүүлэгчийг зөв байрлуулна.
- Халууны шилээ шалган, шүүлтүүрийг хийж, I/O тем товчлуурьг дарна.
- Халууны шилний дэлгэцэн дээр $L^{\circ}\text{C}$ тэмдэгт гарахад хэмжилтийг хийж эхэлнэ.
- Сонсголын сувгийг шулуун болгохын тулд чихийг зөвлөн татааж мэдрэгч чихний хэнгэрэг хоёрыг нэг шугаманд байхаар тааруулан барина.
- Хэмжилт дууссан дохио дуу гармагц хэмжилтийг дуусгана.
- Чихний сувгаас халууны шилийг авахад халууны хэмжилт дэлгэцэн дээр гарна.

Үйлдлийн дараа

- Халууны шилийг халдвартгүйжүүлнэ.
- Хэрэглэсэн зүйлсээ хураана.
- Хог хаягдлыг зааврын ангилан хаяна.
- Гараа угаана/ халдвартгүйжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийн хуудсанд халууныг тэмдэглэнэ.
- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэн тохирох арга хэмжээг авна.

Шулуун гэдсэнд биеийн халуун хэмжих

Хэрэглэгдэх зүйлс:

1. Зориулалтын халууны шил
2. Бээлий
3. Тос
4. Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
5. Халдвартгүйжүүлэх уусмал
6. Цаасан сальфетик
7. Ариун цэврийн цаас
8. Сувилгааны түүх
9. Хар өнгийн бал, үзэг, шугам
10. Хог хаягдлын уут

Хийх үйлдлийн дараалал:

Үйлдлийн өмнө

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйвч дээрх мэдээлэлтэй тулгах).
- Үйлдлийн өмнө эмчлүүлэгчээс халууныг хэмжихээс 30 минутын өмнө хэт халуун, хүйтэн хоол унд хэрэглэсэн эсэх, шатаар өгсөх гэх мэт хэт ачаалал авсан зэргийг асууна.

Үйлдлийн явцад

- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Эмчлүүлэгчдэд хийх гэж буй үйлдлээ тайлбарлана.
- Бээлий өмсөнө.
- Халууны шилний бүрэн бүтэн байдлыг шалгана.
- Халууны шилний үзүүрээс эхлээд ойролцоогоор 2-3 см хүртэлх хэсгийг тосолно.
- Эмчлүүлэгчийг хажуугаар нь хэвтүүлээд хөлийг өвдөгний үеээр нугалан, анусны амсрыг эрхий болон долоовор хуруугаар тэнийлгэж халууны шилний үзүүрийг насанд хүрэгчдэд 3 см, хүүхдэд 2.5 см, нярайд 1.25 см шулуун гэдсэнд зөвлөн оруулна.
- Эмчлүүлэгчийн өгзөгийг хавчиж, халууны шилийг дуугарсны дараа аваад, анус орчмыг ариун цэврийн цаасаар арчина.
- Халууны шилний заалтыг харна.

Үйлдлийн дараа

- Халууны шилийг халдвартайжүүлнэ.
- Хэрэглэсэн зүйлсээ хураана.
- Хог хаягдлыг зааврын ангилан хаяна.
- Гараа угаана/ халдвартайжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийн хуудсанд халууныг тэмдэглэнэ.
- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэн тохирох арга хэмжээг авна.

АМЬСГАЛ ТООЛОХ

Тодорхойлолт

- Бие махбод гаднаас хүчилтөрөгчийг авч, нүүрсхүчлийн хийг гадагшлуулж байгаа хийн солилцоог амьсгал гэнэ. Насанд хүрсэн хүн тайван үедээ 14-20 удаа, хүүхэд насын байдлаас хамааран 40-60 удаа амьсгалдаг байна.

Зорилго

- Нэг минутанд амьсгалах амьсгалын тоо, хэмнэл, хэлбэрийг тодорхойлох

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Үйлчлүүлэгчийн амин үзүүлэлтийг хянах, биеийн байдалд нь үнэлгээ өгөх

Эсрэг заалт

- Байхгүй.

Хэрэглэгдэх зүйлс

1. Чагнуур
2. Секундын хэмжээс бүхий цаг
3. Гар алдвартгүйжүүлэх уусмал
4. Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
5. Сувилгааны түүх
6. Цэнхэр өнгийн бал, шугам
7. Хог хаягдлын уут

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Үйлчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын буруу дээрх мэдээлэлтэй тулгах).
- Үйлдлийн өмнө эмчлүүлэгчээс тамхи татсан эсэх, өтгөн цай, кофе уусан эсэх, биеийн шаардах хөдөлгөөн хийсэн эсэхийг тодруулна.

Үйлдлийн явцад:

- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Хийх гэж буй үйлдлээ танилцуулан зөвшөөрөл авна.
- Эмчлүүлэгчээ зөв байрлуулж (Ямар аргаар тоолох гэж байгаагаас хамаараад), амьсгал тоолоходоо эмчлүүлэгчид мэдэгдэхгүйгээр тайван байх үед нь тоолно.
- Амьсгалын байдлыг үнэлнэ (уруул амны гурвалжин хөхөрсөн эсэх, гар хөлийн үзүүр даарсан, хөхөрсөн эсэх, амьсгалын чимээ, шуугиан, эмгэг амьсгал байгаа эсэх, амьсгалын хэлбэр зэргийг).
- Харж ажиглах аргаар тоолоходоо зузаан хувцасыг нимгэлж амьсгал авах эсвэл гаргах хөдөлгөөний аль нэгийг харж ажиглах аргаар тоолно.
- Тэмтрэх аргаар тоолоходоо хэвлэж цээжин дээр нь эсвэл далан доор хоёр гарын алгыг байрлуулж тоолно.
- Чагнуурын аргаар амьсгалыг тоолоходоо эхлээд цээжийг хоёр талд харьцуулж чагнаад нэг талыг сонгож тоолно.
- Амьсгал авах ба гаргахын аль нэгийг нь сонгон жигд бол 15 секундэд тоолж 4-өөр үржүүлэх эсвэл 30 секунд тоолоод 2-оор үржүүлж нэг минутанд амьсгалах тоог гаргана. Амьсгалын хэмнэл жигд бус байвал 1 минутын турш тоолно.

Үйлдлийн дараа:

- Чагнуур хэрэглэсэн бол халдвартгүйжүүлнэ.
- Хэрэглэсэн зүйлсээ хураана.
- Хог хаягдлыг зааврын дагуу ангилан устгана.
- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийн хуудсанд амьсгалын тоог тэмдэглэнэ.
- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэн тохирох арга хэмжээг авна.

Анхаарах зүйлс

- Амьсгалыг эмчлүүлэгч тайван байх үед тоолох бөгөөд эмчлүүлэгчид амьсгалыг тоолж байгааг мэдэгдэхгүй.
- Амьсгалын хэлбэр, чимээ, өнгөц, гүн эсэхийг харж ажиглана.

- Эмчлүүлэгч амьсалахдаа хүчилж буй эсэхийг анхаарч, амьсгалын үед уушгинд сонсогдож буй дуу авиааг тодорхойлно.
- Амьсгал тоолох үед юм ярихгүй байхыг анхааруулна.
- Хүүхдийг уйлаагүй тайван байх үед нь амьсгалыг тоолно.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Туслах сувилагч, сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч:

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ЦУСНЫ ДАРАЛТ ХЭМЖИХ

Тодорхойлолт

- Судсан дотор урсаж байгаа цус урсах хүчээрээ судасны хананд үзүүлж буй даралтыг цусны даралт гэнэ. Артерийн цусны даралтыг зүрхний булчингийн агших үеийн даралт буюу агшилтын (систол 120 мм.муб) даралт, тэлэх супрах үеийн цусны даралт буюу супралын (диастол 80 мм.муб) даралт гэж ангилацаг. Агшилтын болон супралтын даралтын зөрүүг пульсын даралт гэдэг бөгөөд тогтмол зөрүү нь 30-40 мм.муб байна.

Зорилго

- Артерийн даралтын хэмжээ, хэлбэлзлийн байдлыг тодорхойлох, даралт бууруулах эмчилгээний үр дүнг ажиглах

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Шаардлагатай тохиолдол бүрт

Эсрэг заалт

- Байхгүй

Хэрэглэгдэх зүйлс

1. Чагнуур
2. Сфигмомонометр/даралтын аппарат
3. Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
4. Сувилгааны түүх
5. Бал
6. Хог хаягдлын уут

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйгэвч дээрх мэдээлэлтэй тулгах).
- Үйлдлийн өмнө давсагаа сулласан эсэх, тамхи татсан эсэх, амьсгаадсан эсэх, даралтны эм хэрэглэсэн эсэх, хэвийн үед даралт хэд байдгийг асууна.

Үйлдлийн явцад:

- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Хийх гэж буй үйлдлээ танилцуулан зөвшөөрөл авна.
- Эмчлүүлэгчээ зөв байрлуулна. (Бие даах чадвартай эмчлүүлэгч/үйлчлүүлэгч бол түшлэгтэй сандал налуулан, 2 хөлийг улаар гишгүүлнэ, тэгш гадаргуу дээр гарын алгыг дээш харуулан зүрхний түвшинд байрлуулна.)
- Эмчлүүлэгч/үйлчлүүлэгчийг даралт хэмжих явцад тайван юм ярихгүй байхыг зөвлөөд, дээгүүр өмссөн зузаан, баруу хувцсыг тайлуулж бугалга хэсгийг чөлөөлнө.
- Даралтын аппаратын манжетыг эмчлүүлэгч/үйлчлүүлэгчийн бугалганд 1-2 хуруу орох зйтай, тохойн үенээс дээш 2-4 см байхаар бэхлэнэ (Даралтны аппаратын 2 гуурс тохойн үений урд артерийн дагуу байх).
- Даралтны аппаратын монометрийг эмчлүүлэгчийн зүрхний түвшинд өөрийн нүдэнд харагдахуйц байрлалд байрлуулан манжетад бэхзэнэ.
- Чагнуураа зүүж, тохойн артерийн судас хэсэгт байрлуулна.
- Баллоныг шахаж манжетыг хийлгэхдээ монометрийн заалтыг эмчлүүлэгч/үйлчлүүлэгчийн хэвийн даралтаас 20-30мм/МУБ-аар өндөр байхаар хийлнэ.
- Баллоны хаалтыг аажим нээж монометрийн зүүг 2 мм/сек хурдтайгаар буулгах үед чагнуурт судасны лүгшилтын чимээ сонсогдсон монометрийн зүүний заалтыг харж дээд даралт буюу систолын даралтыг тодорхойлно.
- Судасны лүгшилтын чимээ чагнуурт сонсогдохоо болимогц цусны доод даралт буюу диастолын даралтыг тодорхойлно.
- Баллоныг бүрэн суллан манжетыг авна.
- Нөгөө гарт мөн адил хэмжинэ.

Үйлдлийн дараа:

- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэх арга хэмжээг авна.

- Чагнуурыг халдвартгүйжүүлж, хэрэглэсэн зүйлсээ цэвэрлэн дараагийн хэмжилтэд бэлдэнэ.
- Хог хаягдлыг ангилна.
- Артерийн даралтын хэмжээг хэлж тохирсон зөвлөгөөг өгнө.
- Гараа халдвартгүйжүүлнэ.
- Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийн хуудсанд arterийн даралтыг тэмдэглэнэ.

Анхаарах зүйлс

- Хөх авахуулах мэс засал хийлгэсэн хүний тухайн талын гарыг хэмжихгүй.
- Артери венийн судас залгах /фистуль/ мэс засал хийлгэсэн талын гарыг хэмжихгүй.
- Даралтны аппаратны манжетыг хэт хийлж эмчлүүлэгч/үйлчлүүлэгчийн гарыг бадайруулахаас сэргийлнэ.
- Чагнуурыг болон даралтны аппаратны манжетийг арчиж халдвартгүйжүүлнэ.
- Даралтыг тодорхойлж чадаагүй бол үйлдлийг дахин хийнэ.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Туслах сувилагч, сувилагч, эх баригч, бага эмч, эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

СУДАСНЫ ЛУГШИЛТ ТООЛОХ

Тодорхойлолт

- Судасны лугшилт гэдэг нь зүрхний агшилтын нөлөөгөөр цус судасны ханыг доргиох доргиолтыг хэлнэ. Судасны лугшилтын хурд зүрхний үйл ажиллагаагаар хэмжигдэнэ. Насанд хүрсэн хүний судасны лугшилт минутанд 60-100 байдаг.

Зорилго

- Зүрх судасны үйл ажиллагааг хянах
- Судасны лугшилтын хэм, хүчдэл дүүрэлтийг тодорхойлох

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Шаардлагатай тохиолдол бүрт

Эсрэг заалт

- Байхгүй.

Хэрэглэгдэх зүйлс

1. Цаг
2. Сувилгааны түүх
3. Улаан өнгийн бал
4. Хог хаягдлын уут

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйгээ дээрх мэдээлэлтэй тулгах).
- Өтгөн цай кофе уусан эсэх, тамхи татсан эсэх гэх мэт судасны лугшилтанд нөлөөлех зүйл хэрэглэсэн эсэхийг асууна.

Үйлдлийн явц

- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Хийх гэж буй үйлдлээ танилцуулан зөвшөөрөл авна.
- Эмчлүүлэгчийг ажилбарт бэлэн эсэхийг асууна.
- Эмчлүүлэгчээ хэвтээ эсвэл суугаа байрлалд байрлуулна.
- Эмчлүүлэгчийн хоёр гарын эрхий хуруу дагасан шууны артерийн судсан дээр баруун зүүн гарын 2,3,4-р хурууны өндөгөөр дарж, судасны лугшилтын хүчдэл, дүүрэлт, хэм нь жигд ба жигд бус байгааг тодорхойлно.
- Судасны лугшилтын хэм нь жигд хүчдэл, дүүрэлт нь хоёр гарт ижил байгаа тохиолдолд аль нэг гарыг сонгон судасны лугшилтыг 1 минутын турш эсвэл 15 секунд тоолж түүнийгээ 4-өөр үргүүлж тодорхойлж болно.

Үйлдлийн дараа:

- Хэрэглэсэн зүйлсээ хураана.
- Хог хаягдлыг зааврын дагуу ангилан устгана.
- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийн хуудсанд судасны лугшилтыг тэмдэглэнэ.
- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэн тохирох арга хэмжээг авна.

Анхаарах зүйлс

- Судасны лугшилтын хэм, хүчдэл дүүрэлтийг тодорхойлно.
- Хэм алдагдалтай бол 1 минутын турш тоолно.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Туслах сувилагч, сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ЗАХЫН СУДСАНД ХҮЧИЛТӨРӨГЧИЙН ХАНАМЖ ТОДОРХОЙЛОХ

Тодорхойлолт

- Артерийн цусыг хүчилтөрөгчөөр хангахын тулд хүн хоногт дунджаар 20000 удаа амьсгал авч гаргахдаа 10м3 агаарыг 100м2 талбайгаар (уушгийн нийт талбай) гадагшлуулах ажлыг уушги гүйцэтгэдэг бол зүрх 100000 удаа агшихдаа 86000 км (бүх судасны нийт урт) замаар 7 тонн цусыг шаҳдаг байна. Хүн өөрийн нөөц өөх ба усаа хэрэглээд хоолгүйгээр 1 сар, усгүйгээр 7 хоног амьдарч чаддаг бол ердөө 3 минутын турш амьсгал ба зүрхний цохилт зогсоход хүчилтөрөгчийн нөөц дуусч үхэлд хүрнэ. Хүчилтөрөгчийн ханамж гэдэг нь HbO2 -ыг цусанд агуулагдах нийт Hb-ны хэмжээнд харьцуулсан хувиар илэрхийлэгдэх хэмжээг хэлнэ.

Зорилго

- Захын судсан дах хүчилтөрөгчийн ханамж (SpO_2) тодорхойлох

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийг хянах, хүчилтөрөгчийн ханамжийг тодорхойлох

Эсрэг заалт

- Байхгүй.

Хэрэглэгдэх зүйлс

1. Пульсоксиметр
2. Сувилгааны түүх
3. Бал
4. Гар халдвартгүйжүүлэх уусмал
5. Спирттэй хөвөн
6. Хог хаягдлын уут

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын буруу чадлыг дээрх мэдээлэлтэй тулгах)

Үйлдлийн явц:

- Гараа угаах/халдвартгүйжүүлнэ.
- Хийх гэж буй үйлдлээ танилцуулан зөвшөөрөл авна.
- Эмчлүүлэгчийг ажилбарт бэлэн эсэхийг асууна.
- Эмчлүүлэгчийг тохиромжтой байрлалд байрлуулна.
- Пульсоксиметрийг аль нэг гарын (ихэвчлэн долоовор) хуруунд зүүж, эхлүүлэх товчийг дарна.
- Хэмжилт хийгдэж дуусмагц заалтыг харж пульсоксиметрийг авна.

Үйлдлийн дараа:

- Пульсоксиметрийг халдвартгүйжүүлнэ.
- Хэрэглэсэн зүйлсээ хураана.
- Хог хаягдлыг зааврын дагуу ангилан устгана.
- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтийн хуудсанд SpO_2 -ийг тэмдэглэнэ.
- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэн тохирох арга хэмжээг авна.

Анхаарах зүйлс

- Хэмжиж байх үед эмчлүүлэгчийг тайван суулгана.
- Хэмжилтэнд биеийн байрлал, хурууны хөдөлгөөн, цусны эргэлт, цахилгаан соронзон долгион (TV, гар утас г.м), хумсны будаг лак, тод гэрэлтэх гадаад дотоод хүчин зүйлүүд нөлөөлдөгийг анхаарах хэрэгтэй.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Туслах сувилагч, сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ТУНШЛААС ЭМИЙН БОДИС СОРУУЛАХ АРГА ТЕХНИК

Зорилго

- Тарилгын аюулгүй байдлыг хангах, гарах хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эмийн бодисыг тарихад үйлчлүүлэгчид болон өөрт аюулгүй байлдаар бэлтгэнэ.

Заалт

- Эмийн бодисыг тарихад бэлтгэнэ.

Эсрэг заалт

- Байхгүй

Хэрэглэгдэх зүйлс

1. Тохирох зүү, тариур
2. Туншилтай (ампултай) эмийн бодис
3. Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
4. Нэг удаагийн бээлий (шаардлагатай тохиолдолд)
5. Туншил хөрөөдөгч (шаардлагатай тохиолдолд)
6. Бөөр хэлбэрийн таваг
7. Аюулгүй хайрцаг, хог хаягдлын уут

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө

- Сувилагч хэрэглэгдэх зүйлсээ шалгаж, бэлтгэнэ.

Үйлдлийн явц

- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Бээлий өмсөнө.
- Тохирох зүүг тариурыг сонгон авна. Үүнд: Зүү тариурын бүрэн бүтэн байдал, ариун ба хүчинтэй хугацааг шалгана.
- Тарих эмийн нэр, тунг эмчилгээний хуудастай тулгаж шалгана.
- Туншилтай эмийн бодисын бүрэн бүтэн байдал, ариун ба хүчинтэй хугацааг шалгана.
- Тариурыг уутнаас гаргахын тулд “нээх” гэсэн хэсгээс 2/3 хүртэл задлана.
- Зүүгээ тариурт сайн бэхэлж өгнө.
- Туншилтай эмийн бодис хүзүү хэсэг рүүгээ орсон байвал доош оруулна.
- Туншилтай эмийн бодисыг хүзүүг спирттэй хөвөнгөөр халдвартгүйжүүлж, хөвөнгөөр жийрэглэн хугалж онгойлгох, хугалсан хэсгийг хөвөнтэй чигээр нь аюулгүй хайрцганд хаяна.
- Эмийн бодисыг соруулахдаа нэг гартаар тариурыг нөгөө гартаар эмийн бодисыг барьж соруулна.
- Нэг гарын дүрмээр зүүг таглаж (шаардлагатай тохиолдолд зүүг солих) хийг гаргана.

Үйлдлийн дараа

- Эмийн бодисыг тарина.

Анхаарах зүйлс

- Туншилыг буруу задалсанаас гараа зүсэхээс сэргийлэх
- Туншилтай эмийн бодис хүзүү хэсэг рүүгээ орсон байвал доош нь оруулах
- Сувилагч өөрийгөө гэмтээхээс сэргийлэх

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ФЛАКОНООС ЭМИЙН БОДИС СОРУУЛАХ

Зорилго

- Тарилгын аюулгүй байдлыг хангах, гарах хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эмийн бодисыг тарихад үйлчлүүлэгчид болон өөрт аюулгүй байлдаар бэлтгэнэ.

Заалт

- Эмийн бодисыг тарихад бэлтгэх

Эсрэг заалт

- Байхгүй.

Хэрэглэгдэх зүйлс

1. Тохирох зүү, тариур
2. Нөөц зүү
3. Флаконтой эмийн бодис
4. Физиологийн уусмал (эм найруулах)
5. Халдвартгуйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
6. Нэг удаагийн бээлий (шаардлагатай тохиолдолд)
7. Бөөр хэлбэрийн таваг
8. Аюулгүй хайрцаг, хог хаягдлын уут

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө

- Сувилагч хэрэглэгдэх зүйлсээ шалгаж, бэлтгэнэ.

Үйлдлийн явц

- Гараа угаана.
- Бээлий өмснө.
- Тохирох зүүг тариурыг сонгон авна. Үүнд: Зүү тариурын бүрэн бүтэн байдал, ариун ба хүчинтэй хугацааг шалгана.
- Флаконтой эмийн бодисын бүрэн бүтэн байдал, ариун ба хүчинтэй хугацааг шалгана.
- Тариурыг уутнаас гаргахын тулд нээх гэсэн хэсгээс эхлэн 2/3 хүртэл задлан ариун тавиур дээр тавина.
- Зүүгээ тариурт сайн бэхэлж өгнө.
- Тарих эмийн нэр тунг эмчилгээний хуудастай тулгаж шалгана.
- Тариурт найруулах уусмалыг соруулж авна.
- Флаконтой эмийн төмөр таглааг хямсаагаар авч резинэн тагийг халдвартгуйжүүлнэ.
- Флаконтой эмийн бодисыг тарилгын ширээн (хатуу гадарга) дээр тавьж соруулсан уусмалтай тариурын зүүг флаконы таг уруу хатгана.
- Флаконтой эмийн бодис руу найруулах уусмалаа ханыг дагуулан аажим шахна.
- Флаконоо өөд нь харуулж найруулсан уусмалынхаа хэмжээгээр флакон доторх агаарыг тариурт татаж авна.
- Эмийн бодисыг бүрэн уустал хүлээнэ (гарын хооронд зөөлөн эргүүлж болно).
- Тария найрагдаж дуусмагц шаардагдах тунг соруулан авна.
- Зүүг цэвэр нөөц зүүгээр сольсны дараа хийг гаргана.

Үйлдлийн дараа

- Эмийн бодисыг тарина.

Анхаарах зүйлс

- Флаконоос эмийн бодис соруулсан тохиолдолд заавал зүүг солино.
- Ханыг дагуулан аажим шахах эмийн бодисыг цацарч асгарахаас сэргийлнэ.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

АРЬСАН ДОТОР ТАРИЛГА ХИЙХ

Тодорхойлолт

- Арьсан дотор тарилгыг арьсны өнгөн давхарга болох эпидермесийн давхаргад тарина.

Зорилго

- Антибиотикийн харшлыг илрүүлэх
- Халдварт өвчнийг оношлох (Сүрьеэ, Бруцеллөс гэх мэт)

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, радиологи, хэвтэн эмчлүүлэх тасаг

Залт

- Антибиотик тарихын өмнө
- Халвар өвчин гэж сэжиглэсэн тохиолдолд онош батлах шаардлагатай үед (сүрьеэгийн өвчнийг оношлох манту пиркегийн сорил, бруцеллөс өвчнийг оношлох бүрнегийн сорил, элэгний бэтгэг өвчнийг оношлох кацционы сорил)

Эсрэг заалт

- Тухайн эмийн бодисоос харшилтай гэдэг нь тогтоогдсон
- Тарих талбайн бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтэлтэй

Хэрэглэгдэх зүйлс

1. Сорил тавих эмийн бодис
2. Тариур 1 мл, зүүний хэмжээ (26Gx1/2")
3. Нөөц зүү
4. Шаардлагатай тохиолдол найруулах уусмал
5. Нэрмэл ус
6. Хөвөн бөмбөлөг
7. Ампул хөрөөдөгч
8. Бөөр хэлбэрийн таваг
9. Гар халдвартгүйжүүлэх уусмал
10. Эмчилгээний хуудас, бал
11. Хог хаягдлын уут, аюулгүй хайрцаг

Тарилгын талбай

- Гарын шууны урд талын 3 хуваасны дунд хэсэг
- Далны дээд хэсэг
- Бугалганы ар хэсэг

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бурууич дээрх мэдээлэлтэй тулгах).
- Ямар нэг эмийн бодисоос харшилдаг эсэхийг асууна.

Үйлдлийн явц:

- Гараа угааж/халдвартгүйжүүлнэ.
- Ямар тарилга, ямар зорилгоор, хаана тарихыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчээс тухайн эмийн бодисыг тариулах зөвшөөрөл авна.
- Тарилга хийлгэхэд бэлэн эсэхийг асууна.
- Бээлий өмсөнө.
- Тарих эмийн бодисыг эмчилгээний хуудастай тулгаж шалгана. (Эмийн бодисын 1 дэх тулгалтыг хийнэ.)
- Сувилагч үйлчлүүлэгчид зүү тариур, эмийн бодисын нэр, үйлчилгээ, ариун байдал, хүчинтэй хугацаа, өнгө, тунадас, бүрэн бүтэн байдлыг шалгаж танилцуулна.
- Тухайн эмийн бодисыг өмнө нь тариулж байсан эсэхийг асууна.
- Сорил тавих эмийн бодис флаконтой хуурай тохиолдолд "Флаконоос эмийн бодис соруулах" стандартын дагуу үйлдлийг гүйцэтгэнэ.
- Тариурыг "нээх" гэсэн хэсгээс эхлэн 2/3 хүртэл задалж, ариун дэлгэш дээр тавина.
- 1мл-ийн тариурын зүүгээ үлдээж 22-24G хэмжээтэй сул зүү тариурт угсарна.
- Антибиотикийн сорил тавьж байгаа тохиолдолд тариурт эхлээд натрийн хлоридын 0.9%-ийн уусмалаас 0.9мл хэмжээтэй татаж аваад дараа нь антибиотикоос 0.1мл-ийг соруулж 1мл хэмжээтэй болгоод бөөр хэлбэрийн таваг руу асгаж 0.1-0.3мл-ийг тариурт үлдээж зүүг 26G хэмжээтэй 1мл тариурын үндсэн зүүгээр сольж зүүний налуу

хэсгийг тариурын тоотой хэсэгтэй тохируулан зүүний үзүүрт 1-2 дусал эмийн бодис гаргаж хийг гаргана. (Эмийн бодисын 2 дахь тулгалтыг соруулж байх үедээ хийнэ.)

- Уйлчлүүлэгчийг зөв байрлуулж, тарих талбайг сонгоно.
- Тарилгын талбайг халдвартгүйжүүлэхдээ нэрмэл усаар төвөөс гадагш чиглэлтэй 2-оос доошгүй хөвөн бөмбөлөгөөр халдвартгүйжүүлнэ. (Хэрэв сувилагч тухайн хүнийг спиртнээс харшилгүй эсэхийг баттай мэдсэн тохиолдолд спиртээр талбайг халдвартгүйжүүлж болно гэхдээ талбайг хуурай болсоны дараа хатгалтыг хийнэ.)
- Зүү тариурыг гартаа зөв барина. (Эмийн бодисын 3 дахь тулгалтын хатгахын өмнө хийнэ.)
- Негеө гарцаар арьсыг сайтар тэнийлгэн тарихад эвтэй байдлаар барина.
- Тариураа арьсны гадаргууд 3-5 хэмийн өнцөг үүсгэн барьж, зөвхөн зүүний үзүүрийг арьсанд оруулан хатгаж эмийн бодисыг тарих ба тарилга зөв хийгдсэн тохиолдолд арьсны гадаргууд цэврүү үүснэ.

Үйлдлийн дараа:

- Хэрэглэсэн зүү тариураа нэг гарын дүрмээр шууд аюулгүй хайрцагт хийнэ.
- Хог хаягдлыг ангилан хаяж, хэрэглэсэн зүйлсээ цэгцэлнэ.
- Бээлийгээ тайлна.
- Гараа угааж, халдвартгүйжүүлнэ.
- Тодорхой хугацааны дараа (антибиотикийн сорилыг 15 минутын дараа, сурьеэ өвчний оношлох сорилыг 72 цагийн дараа) сорилын хариуг шалгана.
- Антибиотикийн сорилын хариуг шалгахдаа улайлалт 5 мм дотороо байвал харшилгүй, 6-9мм байвал эргэлзээтэй (өөр талбайд дахин сорил тавина.), 10мм түүтээс дээш байвал харшилтай гэж үзнэ.
- Уйлчлүүлэгчид тохирсон зөвлөгөөг өгнө. (хатгалт хийлгэсэн талбайд ус хүргэж, бохир оруулж майжиж болохгүй гэх мэт)
- Хийсэн тарилгаа бичиж тэмдэглэнэ.

Анхаарах зүйлс

- 10 зөвийн дүрэм баримталж ажиллана.
- Цэврүү үүссэн хэсгийг хөвөн бөмбөлгөөр дарахгүй.
- Сорил тавьсны дараа ус хүргэхгүй, маажихгүй, дааруулахгүй байхыг зөвлөнө.
- Зөвлөгөөг сахиагүй тохиолдолд сорилын хариу буруу гарахыг сануулна.
- Арьсны идээт өвчинүүд, арьсан дээрх эмгэг түуралт, шарх сорви, шивээстэй талбайд сорил тавихгүй.
- Гар солихгүй
- Антигистамины төрлийн эм хэрэглэснээс хойш **7-14 хоногийн** дараа сорил тодорхойлно.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, **эх баригч**, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

АРЬСАН ДОР ТАРИЛГА ХИЙХ

Тодорхойлолт

- Арьсан дор өөхөн эдийн давхаргад хийгдэж буй тарилтыг арьсан дор тарилга гэнэ.

Зорилго

- Эмчилгээний болон оношлогооны

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Арьсан дор тарих заалттай эмийн бодисууд
- Эмчийн заалттай үед

Эсрэг заалт

- Арьсан дор тарьж болохгүй эсрэг заалттай эсийн бодис
- Тухайн эмийн бодисоос харшилтай
- Тарилгын талбайн бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтэлтэй

Хэрэглэгдэх зүйлс

1. Тарих эмийн бодис
2. Тариур 1-3 мл
3. Нөөц зүү 20-23Gx1"-3" (Шаардлагатай тохиолдолд)
4. Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
5. Бээлий
6. Туншил хөрөөдөгч (шаардлагатай тохиолдолд)
7. Наалдуулагч лент
8. Гар халдвартгүйжүүлэх уусмал
9. Бөөр хэлбэрийн таваг
10. Хог хаягдлын уут, аюулгүй хайрцаг
11. Эмчилгээний хуудас, бал

Тарилгын талбай

- Бугалганы гадна ба дотор хажуу
- Далны доод хэсэг
- Хэвлэй, хүйсний орчим
- Өгзөгний дээд хэсэг
- Гуяны урд, гадна хажуу хэсэг

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бурууич дээрх мэдээлэлтэй тулгах).
- Ямар нэг эмийн бодисоос харшилдаг эсэхийг асууна.

Үйлдлийн явц:

- Гараа угааж/халдвартгүйжүүлнэ.
- Ямар тарилга, ямар зорилгоор, хаана тарихыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчээс тухайн эмийн бодисыг тариулах зөвшөөрөл авна.
- Үйлчлүүлэгчээс тарилга хийлгэхэд бэлэн эсэхийг асууна.
- Бээлий өмсөнө.
- Тарих эмийн бодисыг эмчилгээний хуудастай тулгаж шалгана. (Эмийн бодисын 1 дэх тулгалтыг хийнэ.)
- Сувилагч үйлчлүүлэгчид зүү тариур, эмийн бодисын нэр, үйлчилгээ, ариун байдал, хүчинтэй хугацаа, өнгө, тунадас, бүрэн бүтэн байдлыг шалгаж танилцуулна.
- Тухайн эмийн бодисыг өмнө нь тариулж байсан эсэхийг асууна.
- Тариурыг "нээх" гэсэн хэсгээс эхлэн 2/3 хүртэл задалж, ариун дэлгэш дээр тавина.
- Зүүгээ тариурт бэхэлж өгнө.
- Эмийн бодисыг тариурт соруулан хийг гаргана. Шаардлагатай тохиолдолд зүүг солино. (Эмийн бодисын 2 дахь тулгалтыг соруулж байх үедээ хийнэ.)
- Үйлчлүүлэгчийг зөв байрлуулж, тарих талбайгаа зөв сонгоно.
- Тарилгын талбайг төвөөс гадагш чиглэлтэй 2-оос доошгүй хөвөн бөмбөлгөөр халдвартгүйжүүлнэ.

- Зүү тариурыг гартаа зөв барина. (Эмийн бодисын 3 дахь тулгалтын хатгахын өмнө хийнэ.)
- Хатгалт хийх гэж буйгаа урьдчилан сануулна.
- Тарилга хийх талбайн арьсыг чимхэж барина. Зүү тариурыг арьсанд 30-45 хэмийн өнцгөөр хатгаж хэр гүн оруулахыг зүүний хэмжээ болон, тухайн хүний биеийн жин, өөхөн эдийн байдлаас шалтгаална.
- Арьс чимхэсэн гараа суллаж бүлүүрийг хойш татаж, судас таарсан эсэхийг шалгана. Хэрэв судас таарсан бол зүүг сольж өөр талбайд хатгалтыг хийнэ.
- Тарилгыг аажим шахна.
- Зүү, тариурыг сугалан авч нэг гарын дүрмээр аюулгүй хайрцаганд шууд хаяна.
- Тарилга хийсэн талбайг спирттэй хөвөн бөмбөлгөөр дарж наалдуулагч лентээр наана.

Үйлдлийн дараа:

- Хог хаягдлыг ангилан хаяж, хэрэглэсэн зүйлсээ цэгцэлнэ.
- Тарилгын явцад ямар нэг урвал, хүндрэл өгөөгүй бол эмийн бодисын савыг дахин тулгалт хийгээд хаяна.
- Бээлийгээ тайлна.
- Гараа угааж, халдвартгүйжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Хийсэн тарилгыг бичиж тэмдэглэнэ.

Анхаарах зүйлс

- 10 зөвийн дүрэм баримтлан ажиллана.
- Зүү хатгасны дараа судас дайран эсэхийг заавал шалгана.
- Нярай болон хөлд ороогүй хүүхдэд өгзөгний гадна дээд болон гадна хажуу хэсэгт тарилга хийж болохгүй.
- Халдварт хамгаалалын дэглэмийг баримтлан ажиллана.
- Тарилга хийж дуусаад 30 минутын туршид үйлчлүүлэгчийн байдлыг хянана.
- Шаардлагатай тохиолдолд тарилгын өмнө болон дараа амин үзүүлэлтийг хэмжинэ.
- Ямар эмийн бодисыг хаана тарих, тухайн хүний нас, мах марианы байдлаас шалтгаалж зүү тариурыг сонгоно.
- Гар солихгүй

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

БУЛЧИН ТАРИЛГА ХИЙХ

Тодорхойлолт

- Эмчилгээний зорилгоор булчингийн эдэд эмийн бодисыг хийх ажилбарыг булчин тарилга гэнэ. **Булчин тарилгыг шууд хамтгалт** эсвэл **Z track** аргаар тарьж болно. **Z track** аргаар тарих нь эмийн бодис буцаж өөхөн эд рүү шимэгдэх бэрсүү үүсэхээс сэргийлдэг.

Зорилго

- Эмчилгээний

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Булчинд тарих заалттай эмийн бодис
- Эмчийн заалт бичигдсэн үед

Эсрэг заалт

- Булчинд тарьж болохгүй эсрэг заалттай эсийн бодис
- Тухайн эмийн бодисоос харшилтай
- Тарилгын талбайн бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтэлтэй

Хэрэглэгдэх зүйлс

- Тарих эмийн бодис
- Тариур 3-10 мл
- Нөөц зүү 20-23Gx1"-3"
- Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
- Бээлий
- Туншил хөрөөдөгч (шаардлагатай тохиолдолд)
- Наалдуулагч лент
- Гар халдвартгүйжүүлэх уусмал
- Беөр хэлбэрийн таваг
- Хог хаягдлын уут, аюулгүй хайрцаг
- Эмчилгээний хуудас, бал

Тарилгын талбай

- Мөрний булчин (Deltoid)
- Гуяны гадна дунд булчин (Vastus lateralis)
- Гуяны урд дунд булчин (Rectus femoris)
- Өгзөгний гадна дээд булчин (Ventrogluteal)

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйгээ дээрх мэдээлэлтэй тулгах).
- Ямар нэг эмийн бодисоос харшилдаг эсэхийг асууна.

Үйлдлийн явц:

- Гараа угааж/халдвартгүйжүүлнэ.
- Ямар тарилга, ямар зорилгоор, хаана тарихыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчээс тухайн эмийн бодисыг тариулах зөвшөөрөл авна.
- Үйлчлүүлэгчээс тарилга хийлгэхэд бэлэн эсэхийг асууна.
- Бээлий өмсөнө.
- Тарих эмийн бодисыг эмчилгээний хуудастай тулгаж шалгана. (Эмийн бодисын 1 дэх тулгалтыг хийнэ.)
- Сувилагч үйлчлүүлэгчид зүү тариур, эмийн бодисын нэр, үйлчилгээ, ариун байдал, хүчинтэй хугацаа, өнгө, тунадас, бүрэн бүтэн байдлыг шалгаж танилцуулна.
- Тухайн эмийн бодисыг өмнө нь тариулж байсан эсэхийг асууна.
- Тариурыг "нээх" гэсэн хэсгээс эхлэн 2/3 хүртэл задалж, ариун дэлгэш дээр тавина.
- Зүүгээ тариурт бэхэлж өгнө.
- Эмийн бодисыг тариурт соруулан хийг гаргана. Шаардлагатай тохиолдолд зүүг солино. (Эмийн бодисын 2 дахь тулгалтыг соруулж байх үедээ хийнэ.)


- Үйлчлүүлэгчийг зөв байрлуулж (мөрний булчинд тарьж байгаа тохиолдолд хэвтүүлэх эсвэл суулгаж нэг гараараа тарилга хийж байгаа талын тохойг түшүүлнэ. Өгзөг болон гуяны булчинд тарьж байгаа тохиолдолд хэвтүүлнэ.), тарих талбайгаа зөв сонгоно.
- Тарилгын талбайг төвөөс гадагш чиглэлтэй 2-оос доошгүй хөвөн бөмбөлгөөр халдвартгүйжүүлнэ.
- Зүү тариурыг гартаа зөв барина. (Эмийн бодисын 3 дахь тулгалтын хатгахын өмнө хийнэ.)
- Хатгалт хийх гэж буйгаа урьдчилан сануулна.

Шууд хатгалтын арга:

- Тарилга хийх талбайн арьсыг нэг гараараа тэндийлгэнэ. Эмийн бодистой зүү тариурыг арьсанд 90 хэмийн өнцгөөр хатгаж хэр гүн оруулахыг зүүний хэмжээ болон, тухайн хүний биеийн жин, өөхөн эд, булчингийн массаас шалтгаална.
- Арьс тэндийлгэсэн гарцаа суллаж бүлүүрийг хойш татаж, судас таарсан эсэхийг шалгана. Хэрэв судас таарсан бол зүүг сольж өөр талбайд хатгалтыг хийнэ.
- Тарилгыг аажим шахна.

Z track арга:

- Тарилга хийх талбайн арьсыг зүүн гарцаараа татна. Баруун гартаа эмийн бодистой зүү тариурыг барьж 90 хэмийн өнцгөөр хатгаж хэр гүн оруулахыг зүүний хэмжээ болон, тухайн хүний биеийн жин, өөхөн эд, булчингийн массаас шалтгаална.
- Баруун гартаа барьсан зүү тариурыг зүүн гарын эрхий долоовор хуруунд шилжүүлнэ. Гэхдээ татсан арьсыг суллахгүй.
- Баруун гарцаараа бүлүүрийг хойш татаж, судас таарсан эсэхийг шалгана. Хэрэв судас таарсан бол зүүг сольж өөр талбайд хатгалтыг хийнэ.
- Эмийн бодисыг аажим шахна.
- Зүүг эвтэй сугалан авсаны дараа татсан арьсыг суллана. (Зураг 1. Z track аргыг харна уу)



Зураг 1. Z track арга

- Зүү, тариурыг сугалан авч нэг гарын дүрмээр аюулгүй хайрцаганд шууд хаяна.
- Тарилга хийсэн талбайг спирттэй хөвөн бөмбөлгөөр дарж наалдуулагч лентээр наана.

Үйлдлийн дараа:

- Хог хаягдлыг ангилан хаяж, хэрэглэсэн зүйлсээ цэгцэлнэ.
- Тарилгын явцад ямар нэг урвал, хүндрэл өгөөгүй бол эмийн бодисын савыг дахин тулгалт хийгээд хаяна.
- Бээлийгээ тайлна.
- Гараа угааж, халдвартгүйжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Хийсэн тарилгыг бичиж тэмдэглэнэ.

Анхаарах зүйлс:

- 10 зөвийн дүрэм баримтлан ажиллах
- Халдвартгүйжүүлнэ дэглэмийг баримтлан ажиллана.
- Тарилга хийж дуусаад 30 минутын дараа үйлчлүүлэгчийн байдлыг хянана.

- Шаардлагатай тохиолдолд тарилгын өмнө болон дараа амин үзүүлэлтийг хэмжинэ.
- Өгзөг болон гуяны хэсгийн булчинд тарилга хийхдээ үйлчлүүлэгчийг заавал хэвтүүлж тарина.
- Тарилга хийж дуусаад 30 минутын туршид үйлчлүүлэгчийн байдлыг хянана.
- Нярай болон хөлд ороогүй хүүхдэд өгзөгний гадна дээд болон гадна хажуу хэсэгт тарилга хийж болохгүй.
- Зүү хатгасны дараа судас таарсан эсэхийг заавал шалгана.
- Тарилга хийсэн талбай дээр тавьсан хөвөн бөмбөлөг дээр хэт чанга дарах, массаж хийж болохгүйг анхааруулна.
- Ямар эмийн бодисыг хаана тарих, тухайн хүний нас, мах мярианы байдлаас шалтгаалж зүү тариурыг сонгоно.
- Z track аргаар зөвхөн өгзөг болон гуяны булчинд тарина.
- Гар солихгүй

Үйлдлийг гардан гүйцэтгэгч:

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч:

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ХУРААГУУР СУДСАНД ТАРИЛГА ХИЙХ

Тодорхойлолт

- Венийн буюу хураагуур судсанд эмийн бодисыг тарихыг судас тарилга гэнэ.

Зорилго

- Эмчилгээ, оношилгооны

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Судсанд тарих заалттай эмийн бодис
- Эмчийн заалт бичигдсэн үед

Эсрэг заалт

- Судсанд тарьж болохгүй эсрэг заалттай эсийн бодис
- Тухайн эмийн бодисоос харшилтай
- Тарилгын талбайн бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтэлтэй

Хэрэглэгдэх зүйлс

1. Тарих эмийн бодис
2. Тариур 3-20мл
3. Нөөц зүү 20-23Gx1"-3"
4. Чангалуур
5. Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
6. Бээлий
7. Туншил хөрөөдөгч (шаардлагатай тохиолдолд)
8. Наалдуулагч лент
9. Гар халдвартгүйжүүлэх уусмал
10. Бөөр хэлбэрийн таваг
11. Хог хаягдлын уут, аюулгүй хайрцаг
12. Эмчилгээний хуудас, бал

Тарилгын талбай

- Тохойн урд талын вен
- Шууны гадна талыг дагасан вен
- Шууны ботгос ясыг дагасан вен
- Сарвууны гадна талын вен
- Сарвууны гадна талын нуман вен
- Эрхий хурууны арын вен
- Чамархайн вен
- Хөлийн сарвууны дунд вен
- Шагайн үүний дотор талын бүдүүн вен
- Шагайн үүний гадна талын нарийн вен

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйвч дээрх мэдээлэлтэй тулгах).
- Ямар нэг эмийн бодисоос харшилдаг эсэхийг асууна.

Үйлдлийн явц:

- Гараа угааж/халдвартгүйжүүлнэ.
- Ямар тарилга, ямар зорилгоор, хаана тарихыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчээс тухайн эмийн бодисыг тариулах зөвшөөрөл авна.
- Үйлчлүүлэгчээс тарилга хийлгэхэд бэлэн эсэхийг асууна.
- Бээлий өмсөнө.
- Тарих эмийн бодисыг эмчилгээний хуудастай тулгаж шалгана. (Эмийн бодисын 1 дэх тулгалтыг хийнэ.)
- Сувилагч үйлчлүүлэгчид зүү тариур, эмийн бодисын нэр, үйлчилгээ, ариун байдал, хүчинтэй хугацаа, өнгө, тунадас, бүрэн бүтэн байдлыг шалгаж танилцуулна.
- Тухайн эмийн бодисыг өмнө нь тариулж байсан эсэхийг асууна.
- Тариурыг "нээх" гэсэн хэсгээс эхлэн 2/3 хүртэл задалж, ариун дэлгэш дээр тавина.
- Зүүгээ тариурут бэхэлж өгнө.

- Эмийн бодисыг тариурт соруулан хийг гаргана. Шаардлагатай тохиолдолд зүүг солино. (Эмийн бодисын 2 дахь тулгалтыг соруулж байх үедээ хийнэ.)
- Үйлчлүүлэгчийг зөв байрлуулж, тарих талбайгаа зөв сонгоно.
- Шаардлагатай тохиолдолд ивүүрийг байрлуулна.
- Чангалаурыг **хатгах судаснаас** 2-4 см орчим дээр чангалаурыг зөвхөн хураагуур судасны ургалыг хааж тараагуур судасны лугшилт мэдэгдэж байхаар бэхэлнэ.
- Тарилгын талбайг цусны ургалын дагуу 2-оос доошгүй хөвөн бөмбөлгөөр халдвартгүйжүүлнэ.
- Хатгалт хийх гэж буйгаа урьдчилан сануулна.
- Тарилга хийх талбайн арьсиг нэг гараараа доош тэнийлгэн татна. Нэг гараараа зүү тариурыг арьсанд 25 хэмийн өнцөгөөр хатгаж, судсанд 10-15 хэмийн өнцөгөөр хатгана. (Судасны байрлал, зүүний хэмжээнээс хамаарч болно.)
- Зүү судсанд орсон гэж үзсэн тохиолдолд арьсиг тэнийлгэсэн гараа суллаж бүлүүрээ хойш нь татаж шалгана.
- Тариурт цус орж ирсэн тохиолдолд чангалаурыг аажим суллана.
- Тариаг аажим шахна. Шаардлагатай тохиолдолд судсандаа зүү байгаа эсэхийг бүлүүрийг хойш татаж шалгана.
- Тарилгын явцад үйлчлүүлэгчийн царайг ажиглан ямар нэг зовиур илэрч байгаа эсэхийг асууна.
- Зүү, тариурыг сугалан авна. Нэг гарын дүрмээр аюулгүй хайрцаганд шууд хаяна.
- Тарилга хийсэн талбайг спирттэй хөвөн бөмбөлгөөр даран наалдуулагч лентээр наана.

Үйлдлийн дараа:

- Хог хаягдлыг ангилан хаяж, хэрэглэсэн зүйлсээ цэгцэлнэ.
- Эмийн бодис тарилгын явцад ямар нэг урвал, хүндрэл өгөөгүй бол 3 дахь тулгалтыг хийгээд хаяна.
- Бээлийгээ тайлна.
- Гараа угааж, халдвартгүйжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Хийсэн тарилгыг бичиж тэмдэглэнэ.

Анхаарах зүйлс

- 10 зөвийн дүрэм баримтлан ажиллана.
- Халдварт хамгаалалын дэглэмийг баримтлан ажиллана.
- Тарилга хийж дуусаад 30 минутын дараа үйлчлүүлэгчийн байдлыг хянана.
- Шаардлагатай тохиолдолд тарилгын өмнө болон дараа амин үзүүлэлтийг хэмжинэ.
- Хэт даарсан тохиолдолд дулаацуулна.
- Судсыг олохгүй байгаа тохиолдолд шингэн зүйл уулгах, дулаацуулсаны дараа хатгалтыг хийнэ.
- Ямар эмийн бодисыг хаана тарих, тухайн хүний нас, мах мярианы байдлаас шалтгаалж зүү тариурыг сонгоно.
- Гар солихгүй
- Тарилга хийсэн талбай дээр тавьсан хөвөн бөмбөлөг дээр хэт чанга дарах, массаж хийж болохгүй анхааруулна.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ХУРААГУУР СУДСАНД ДУСЛААР ШИНГЭН СЭЛБЭХ

Тодорхойлолт

- Судсаар хийх зарим төрлийн тарилгыг дуслаар хийх боломжтой. Дусал тарилга хийх үйлдэл нь сувилахуйн тусlamж үйлчилгээнд өргөн хэрэглэгддэг бөгөөд сувилагчаас мэдлэг, чадвар, хандлага шаардсан ажилбарт ордог. Дуслаар хийгдэх эмийн бодис нь 50-500 мл хүртэл хэмжээгээр савлагдсан байдаг

Зорилго

- Эмчилгээ, оношилгооны

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусlamж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Судсанд тарих заалттай эмийн бодис
- Хордлого тайлах
- Алдагдсан шингэний нөхөх
- Бие махбодод шингэн дутагдахад шингэн нөхөх
- Үйлчлүүлэгч юм идэж ууж чадахгүй байгаа тохиолдолд судсаар тэжээлийн бодис оруула
- Эмчийн заалтаар бичигдсэн үед

Эсрэг заалт

- Судсанд тарьж болохгүй эсрэг заалттай эсийн бодис
- Тухайн эмийн бодисоос харшилтай
- Тарилгын талбайн бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтэлтэй

Хэрэглэгдэх зүйлс

1. Дуслаар тарих эмийн бодис
2. Систем
3. Чангалуур
4. Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
5. Бээлий
6. Дуслын хөл
7. Туншил хөрөөдөгч (шаардлагатай тохиолдолд)
8. Наалдуулагч лент
9. Гар халдвартгүйжүүлэх уусмал
10. Бөөр хэлбэрийн таваг
11. Хог хаягдлын уут, аюулгүй хайрцаг
12. Эмчилгээний хуудас, бал

Тарилгын талбай

- Тохойн урд хонхорын вен
- Шууны гадна талыг дагасан вен
- Шууны ботгос ясыг дагасан вен
- Сарвууни гадна талын вен
- Сарвууни гадна талын нуман вен
- Эрхий хурууны арын вен
- Чамархайн вен
- Хелийн сарвууны дунд вен
- Шагайн үений дотор талын бүдүүн вен
- Шагайн үений гадна талын нарын вен

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйгэвч дээрх мэдээлэлтэй тулгах).
- Ямар нэг эмийн бодисоос харшилдаг эсэхийг асууна.

Үйлдлийн явц:

- Гараа угааж/халдвартгүйжүүлнэ.
- Ямар тарилга, ямар зорилгоор, хаана тарихыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчээс тухайн эмийн бодисыг тариулах зөвшөөрөл авна.
- Үйлчлүүлэгчээс тарилга хийлгэхэд бэлэн эсэхийг асууна.

- Бээлий өмсөнө.
- Дуслаар тарих эмийн бодисыг эмчилгээний хуудастай тулгаж шалгана. (Эмийн бодисын 1 дахь тулгалтыг хийнэ.)
- Сувилагч үйлчлүүлэгчид зүү тариур, систем, эмийн бодисын нэр, үйлчилгээ, ариун байдал, хүчинтэй хугацаа, өнгө, тунадас, бүрэн бүтэн байдлыг шалгаж танилцуулна.
- Тухайн эмийн бодисыг өмнө нь тариулж байсан эсэхийг асууна.
- Системийг угсрал хийг гарган бэлтгэж штативт байрлуулна. (дуслаар тарих эмийн бодисын 2 дахь тулгалтыг хийнэ.)
- Үйлчлүүлэгчийг зөв байрлуулж, тарих талбайгаа зөв сонгоно.
- Шаардлагатай тохиолдолд ивүүрийг байрлуулна.
- Чангалуурыг **хатгах судаснаас** 2-4 см орчим дээр чангалуурыг зөвхөн хураагуур судасны ургалыг хааж тараагуур судасны лугшилт мэдэгдэж байхаар бэхэлнэ.
- Тарилгын талбайг цусны ургалын дагуу 2-оос доошгүй хөвөн бөмбөлгөөр халдвартгуйжүүлнэ.
- Системд хий байгаа эсэхийг дахин нэг шалгана.
- Системийн зүүг зөв барина. (Эмийн бодисын 3 дахь тулгалтын хатгахын өмнө хийнэ.)
- Хатгалт хийх гэж буйгаа урьдчилан сануулна.
- Тарилга хийх талбайн арьсыг нэг гараараа доош тэнийлгэн татна. Нэг гараараа зүү тариурыг арьсанд **25 хэмийн өнцөгөөр** арьсаа цоолж, судсанд **10-15 хэмийн өнцөгөөр** хатгана. (**Судасны байрлал, зүүний хэмжээ болон, тухайн хүний мах мярианы байдлаас шалтгаалж хэмийг тохируулна.**)
- Зүү судсанд орсон тохиолдолд (зүүний углуургад цус үзэгдмэгц) чангалуурыг суллаж, дуслын хурдыг тохируулна.
- Дусал тарилга тодорхой хугацаанд үргэлжлэх тул зүүг арьстай бэхэлж нааж өгнө.

Үйлдлийн дараа:

- Хог хаягдлыг ангилан хаяж, хэрэглэсэн зүйлсээ цэгцэлнэ.
- Эмийн бодис тарилгын явцад ямар нэг урвал, хүндэрэл өгөөгүй бол дахин тулгалтыг хийгээд хаяна (Дусал тарилга дууссаны дараа).
- Бээлийгээ тайлна.
- Гараа угааж, халдвартгуйжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Хийсэн тарилгыг бичиж тэмдэглэнэ.

Анхаарах зүйлс

- 10 зөвийн дүрэм баримтлан ажиллана.
- Дусал тарилгын 1 минутанд дусах тоог тохируулна.
- Халдварт хамгаалалтын дэглэмийг баримтлан ажиллана.
- Дусал тарилгын явцад үйлчлүүлэгчийн биеийн байдлыг ажиглана.
- Дусал тарилга хийж дуусаад 30 минутын дараа үйлчлүүлэгчийн байдлыг хянана.
- Шаардлагатай тохиолдолд тарилгын өмнө болон дараа амин үзүүлэлтийг хэмжинэ.
- Хэт даарсан тохиолдолд дулаацуулна.
- Судсыг олохгүй байгаа тохиолдолд шингэн зүйл уулгах, дулаацуулсаны дараа хатгалтыг хийнэ.
- Тарилга хийсний дараа тарилга хийсэн талбай дээр тавьсан хөвөн бөмбөлөг дээр дарж массаж хийж болохгүй анхааруулна.
- Тохирох хэмд хадгалсан шингэнгийг хийнэ.
- Судас хатгах үйл ажиллагааны буруугаас судсанд хий орж, хийн бөглөөс үснэ.
- Хэт хүйтэн эмийн бодисыг тарихгүй.
- Толгой эргэх чих шуугих амьсгал давчдах, зүрх дэлсэх, ууц нуруугаар хөших, цусны даралт, биеийн халуун, судасны лугшилт хэвийн хэмжээнээс өөрчлөгдхөн зэрэг хариу урвалын шинж тэмдэг илэрвэл дуслыг зогсоож шаардлагатай арга хэмжээг авна.
- Дусал тарилга хийх эмчилгээний явцад шээсний гарцыг сайтар хянана.
- Дусал тарилгын өмнө болон хойно амин үзүүлэлтүүдийг хэмжиж тэмдэглэсэн байна.
- Дусал тарилгын явцад унтаж болохгүй анхааруулна.
- Гар солихгүй.
- Үйлчлүүлэгчийг орон дээр хэвтүүлж дулаан хучиж дусал тарилгыг хийнэ.
- Цонх онгорхой бол хаана.

Үйлдлийг гардан гүйцэтгэг

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ХУРААГУУР СУДАСНААС ЦУСНЫ ШИНЖИЛГЭЭ АВАХ

Тодорхойлолт

- Хураагуур судас хатгаж цусны шинжилгээ авах

Зорилго

- Оношилгооны

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Хураагуур судаснаас цус авах бүх шинжилгээг авна.
- Шинжилгээ авах эмчийн заалттай үед

Эсрэг заалт

- Хатгах талбайн арьсны бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтэлтэй

Хэрэглэгдэх зүйлс

1. Хуруу шил (тухайн шинжилгээг авах зориулалтын)
2. Шинжилгээний зүү
3. Чангалуур
4. Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
5. Бээлий
6. Туншил хөрөөдөгч (шаардлагатай тохиолдолд)
7. Наалдуулагч лент
8. Гар халдвартгүйжүүлэх уусмал
9. Беөр хэлбэрийн таваг
10. Хог хаягдлын уут, аюулгүй хайрцаг
11. Шинжилгээний захиалгын хуудас (Баркод), бал

Тарилгын талбай

- Тохойн урд хонхорын вен
- Шууны гадна талыг дагасан вен
- Шууны богтос ясиг дагасан вен
- Сарвууны гадна талын вен
- Сарвууны гадна талын нуман вен
- Эрхий хурууны арын вен
- Чамархайн вен
- Хөлийн сарвууны дунд вен
- Шагайн үений дотор талын бүдүүн вен
- Шагайн үений гадна талын вен

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйвч дээрх мэдээлэлтэй тулгах).

Үйлдлийн явц:

- Гараа угааж/халдвартгүйжүүлнэ.
- Юуны шинжилгээг, ямар зорилгоор, хаанаас авахыг танилцуулна.
- Шинжилгээ өгөх зөвшөөрөл авна.
- Үйлчлүүлэгчээс шинжилгээ өгөхөд бэлэн эсэхийг асууна.
- Бээлий өмснө.
- Шинжилгээ авах үйлчлүүлэгчийг мөн эсэх, сорьцыг зөв хуруу шилэнд цуглуулах гэж байгаа эсэхээ дахин шинжилгээний захиалгын хуудастай тулгана.
- Өмнө нь шинжилгээ өгч байсан эсэх, өглөө юм идэж, уусан (юуны шинжилгээ авах гэж байгаагаас шалтгаална.) эсэхийг тодруулна.
- Үйлчлүүлэгчид шижилгээний зүү, хуруу шил зэрэг хэрэглэгдэхүүний ариун байдал, хүчинтэй хугацаа бүрэн бүтэн байдлыг шалгаж танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв байрлуулж, хатгалтын талбайгаа зөв сонгоно.
- Шаардлагатай тохиолдолд ивүүрийг байрлуулна.
- Чангалуурыг **хатгах судаснаас** 2-4 см орчим дээр чангалуурыг зөвхөн хураагуур судасны урсгалыг хааж тараагуур судасны лугшилт мэдрэгдэж байхаар бэхэлнэ.

- Хатгалт хийх талбайг цусны урсгалын дагуу 2-оос доошгүй хөвөн бөмбөлгөөр халдвартгүйжүүлнэ.
- Хатгалт хийх гэж буйгаа урьдчилан сануулна.
- Шинжилгээний зүүг 25 хэмийн налуугаар эхлээд арьсыг, дараа нь судсыг 10-15 хэмийн өнцөгөөр хатгах дарааллаар зүүг хатгаж зүү судсанд орсон тохиолдолд (зүүний углуургад цус үзэгдэнэ) сорьц цуглуулах хуруу шилтэй холбож сорьцыг зөв дарааллын дагуу цуглуулна.
- Сүүлийн хуруу шилэнд сорьц зохистой хэмжээнд хүрмэгц эхлээд чангалаураа сулаад, хуруу шилээ зүүнээс сугалж аваад дараа нь зүүг сугалан авна.
- Зүүг нэг гарын дүрмээр аюулгүй хайрцаганд шууд хаяна.
- Хатгалт хийсэн талбайд спирттэй хөвөн тавьж наана.

Үйлдлийн дараа:

- Хог хаягдлыг ангилан хаяж, хэрэглэсэн зүйлсээ цэгцэлнэ.
- Сорьцыг авсаны дараа дахин овог, нэр, он сар өдрийг дахин тулгалт хийж баркодыг наана.
- Бээлийгээ тайлна.
- Гараа угааж, халдвартгүйжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Сорьцыг 2 цагийн дотор лабораторид хүргэнэб
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ.

Анхаарах зүйлс

- (Биохимийн шинжилгээ авах гэж байгаа бол өлөн эсэх, цусан дахь сахарын хэмжээ тодорхойлох гэж байгаа тохиолдолд хамгийн сүүлд хэзээ юм идсэн эсэхийг асуух)
- Халдварт хамгаалалын дэглэмийг баримтлан ажиллах
- Хэт даарсан тохиолдолд дулаацуулах
- Судсыг олохгүй байгаа тохиолдолд шингэн зүйл уулгах, дулаацуулсаны дараа хатгалтыг хийх
- Сорьц авсаны дараа тарилга хийсэн талбай дээр тавьсан хөвөн бөмбөлөг дээр дарж массаж хийж болохгүй анхааруулах.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ЗАХЫН ХУРААГУУР СУДСАНД УЯН ЗҮҮ ТАВИХ

Тодорхойлолт

- Уян зүү нь уян хатан чанартай хэрэглэх үед судсанд гэмтэл үүсгэдэггүй, эмчлүүлэгчийн хөдөлгөөнд саад учруулдаггүй, эмчилгээг нэг хатгалтаар аюулгүй удаан хугацаанд хийх боломжтой учир сүүлийн үед эмчилгээнд өргөн хэрэглэгдэж байгаа сувилахуйн гардан ажилбарын нэг юм.

Зорилго

- Хүүхэд болон биеийн байдал хүнд эмчлүүлэгчид нэмэлт зовиур учруулахгүй байх зорилгоор олон хатгалтаас сэргийлэх, хатгалтын тоог цөөрүүлэх, найдвартай судсаар эмчилгээг (тариа, шингэн, цус цусан бүтээгдэхүүн) цаг алдалгүй хийж гүйцэтгэх

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусlamж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Шаардлагатай тохиолдолд эмчийн заалтаар
- Венийн судсанд эмийн бодисыг оруулах
- Үс эрдэсийг нөхөх, судсаар тэжээх, алдсан цусыг нөхөх
- Шингэн хурдан хугацаанд сэлбэх
- Яаралтай тусlamжийн үед
- Эрчимт эмчилгээ
- Мэс заслын үед
- Хураагуур судас олдоц муу үед

Эсрэг заалт

- Байхгүй

Хэрэглэгдэх зүйлс

1. Тарих эмийн бодис
2. Тохирох уян зүү
3. Зүү тариур /шаардлагатай тохирох хэмжээгээр нь/
4. Натри хлоридын 0.9% /шалгах уусмал/
5. Үзлэгийн бээлий
6. Ариун бээлий
7. Халдвартгүйжүүлэх уусмал бүхий хөвөн бөмбөлөг (alcohol prep pad 70%)
8. Талбай халдвартгүйжүүлэх тамедин 2.5%
9. Ариун хямсаа
10. Чангалуур, ивүүр
11. Уян зүүний наалт
12. Хайч
13. Ариун бэхлэх бинт /шаардлагатай тохиолдолд/
14. Уян зүүний салаалагч /шаардлагатай тохиолдолд/
15. Уян зүүний нэг удаагийн таг
16. Аюулгүй хайрцаг
17. Хог хаягдлын уут, сав
18. Гар халдвартгүйжүүлэх уусмал
19. Аюулгүй хайрцаг, хог хаягдлын уут
20. Эмчилгээний хуудас
21. Судасны гурстай холбоотой хуудсыг тандах хуудас, бал

Тарилгын талбай

- Дээд болон доод мөчдийн хураагуур судаснууд
- Гарын сарвууны арын хураагуур судаснууд
- Гарын шууны хураагуур судаснууд
- Эрхий хурууны арын хураагуур судас
- Тохойн урд талын венийн судас
- Хөлийн тавхайн дээд хэсэг венийн судас
- Чамархайн хураагуур судас

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.

- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Оөг, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын буруйн дээрх мэдээлэлтэй тулгах).
- Өмнө нь уян зүү тавиулж байсан эсэхийг асууна.

Үйлдлийн явц:

- Гараа угааж/халдвартгүйжүүлнэ.
- Уян зүүний тухай, уян тавихын зорилго, ач холбогдол мөн эрсдэлийн талаар танилцуулна.
- Уян зүү тавиулах зөвшөөрөл авна.
- Уян зүү тавиулахад бэлэн эсэхийг асууна.
- Бээлий өмсөнө.
- Уян зүү, эмийн бодисын хэмжээ, бусад хэрэглэгдэх зүйлсийн хүчинтэй хугацаа, ариун байдлыг шалгаж, үйлчлүүлэгчид чанга дуугаар уншиж танилцуулна.
- Уян зүүг шалгах зорилгоор натрийн хлоридын 0.9%-ийн уусмалыг 2-3 мл-ыг тариурт соруулж бэлтгэнэ.
- Талбайг сонгож (аль болох шулуун том судас сонгох) үйлчлүүлэгчийг байрлуулна.
- Ариун бээлийг задалж бээлийний дотор талын цаасыг дэлгэш болгож хэрэглэнэ.
- Уян зүү, уян зүүний наалтыг ариун дэлгэш дээр гартаа хүрэхгүйгээр унагаах маягаар задалж бэлдэнэ.
- Уян зүү тавих талбайг тамидины 7.5%-ийн уусмалтай хөвөнгөөр дараа нь спирттэй хөвөнгөөр эхлээд судас дагуу дараа нь 2 тал руу нэг арчсан хэсэгтээ дахиж арчихгүйгээр халдвартгүйжүүлнэ.
- Чанггуурыг хатгах судаснаас 2-4 см орчим дээр хураагуур судасны урсгалыг хааж тараагуур судасны лугшилт мэдэгдэж байхаар бэхэлнэ.
- Энгийн бээлийгээ тайлна.
- Гараа халдвартгүйжүүлээд ариун бээлийг өмсөнө.
- Уян зүүг авч тагийг суллаад 25 хэмийн өнцгөөр арьсаа, 10-15 хэмийн өнцгөөр судсыг хатгаж зүүний утг цус орж ирмэгц чанггуурыг суллан төмөр зүүг нааш татах хөдөлгөөнтэй зэрэгцүүлэн уян зүүг цааш түлхэнэ.
- Төмөр зүүг авмагцаа хатгасан судасны дээр дарж цусны урсгалыг хааж, спирттэй хөвөнг уян зүүний доор байрлуулна.
- Тариурт бэлдсэн натрийн хлоридын 0.9%-ийн уусмалыг уян зүүтэй угсарч шахаад зүү судсанд байгаа эсэхийг шалгаад уян зүүний тагийг таглана.
- Уян зүүг зориулалтын наалтаар наана.
- Уян зүүний наалтан дээр он, сар, өдөр, цагийг бичнэ.
- Бинтээр уян зүүг бэхэлнэ.

Үйлдлийн дараа:

- Хог хаягдлыг ангилан хаяж, хэрэглэсэн зүйлсээ цэгцэлнэ.
- Судасны гурстай холбоотой халдвартыг тандах хуудсыг нээж бичнэ.
- Бээлийгээ тайлна.
- Гараа угааж, халдвартгүйжүүлнэ.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ.

Анхаарах зүйлс

- Эмчилгээний өмнө (уян зүүг шалгах) болон дараа (уян зүүг цэвэрлэх) уян зүүгээр натрийн хлоридын 0.9%-ийн уусмал 10 мл-ийг шахна.
- Уян зүүг судсанд, 72 цагаас удаан хугацаагаар байлгахгүй байх, шаардлагатай бол өөр судсыг сонгож дахин тавих.
- Уян зүүний тандалтын хуудсыг ээлж бүрийн сувилагч үргэлжлүүлэн хөтөлнө.
- Сувилагч нар ээлж хүлээлцэхдээ уян зүүтэй эмчилүүлэгчийг нэг бүрчлэн хүлээлцэнэ.
- Уян зүү судаснаас гарсан, үрэвслийн шинж илэрсэн, өвдөлттэй, 72 цаг болсон тохиолдолд шууд авна.
- Уян зүүний бэхэлгээ хийсэн боолтыг бохирдсон даруйд солино.
- Халдвартын сэргийлэлт, хяналтын дэглэмийг баримтлана.
- Уян зүү тавьсан талбайг бохирдуулахгүй байх, зүүгээ сугалахаас болгоомжлох, зүү тавьсан гараар хүнд юм өргөхгүй байх гэх мэт тохирсон зөвлөгөөг өгнө.

Үйлдлийг гардан гүйцэтгэг

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

БУМБА ТАВИХ

Тодорхойлолт

- Бумбан дотор агааргүй орчин үүсгэн, биеийн арьсан дээр тавьснаар соролт үүсгэж хэсэг газрын цусны судасны өргөсөлт болж арьс улайх үйл явцыг бумба тавих гэнэ.

Зорилго

- Хэсэг газрын мэдрэлжүүлэлт, цус, тунгалаг, хийн эргэлтийг сайжруулснаар үрэвсэл дарж, өвдөлтийг намдаах, цэр ховхлох, халуун бууруулах, амьсгаадалтыг намдаах, хэвтрийн хатгаанаас сэргийлэхэд оршино.

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Уушгины үрэвсэл
- Гуурсан хоолойн үрэвсэл
- Өвөрмөц бус уушигны зогсонгишил
- Ууц, нуруу, цээжний өвдөлт
- Тулгуур эрхтэний эмгэгүүд
- Хэвтрийн хатгалгаанаас урьдчилан сэргийлэх

Бумба тавих талбай

- Цээжний ард багана нурууны 2 талд
- Сэргээн дээр
- Өгзөг, гуяны ар талбайд

Бумба тавьж болохгүй талбай

- Зүрхний орчим
- Хөхөн дээр
- Нурууны нугаламын хэсэг

Эсрэг заалт

- Уушгинаас цус алдаж байгаа үед
- Уушгины сурьеэгийн идэвхитэй хэлбэр
- Уушгины болон цээжний хэсгийн хорт хавдар
- Цусны бүлэгнэлтийн өөрчлөлттэй үед
- Архаг цус багадалт
- Бумба тавих газар хавантай
- Арьсны идээт үрэвсэл болон ямар нэг тууралт
- Арьс хэт их мэдрэг үед
- Өндөр халуунтай үед
- Бие махбодь хэт суларсан үед

Хэрэглэгдэх зүйлс

1. Бумба (хэрэглэгдэх тоогоор)
2. Гар халдвартгүйжүүлэх уусмал
3. Хямсаа
4. Спирт
5. Хөвөн
6. Вазелин
7. Бөөр хэлбэрийн таваг
8. Үс далдах алчуур
9. Бие арчих алчуур
10. Түмпэнтэй бүлээн ус
11. Бумба арчих алчуур
12. Дулаан хучлага.

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйвч дээрх мэдээлэлтэй тулгах)

Үйлдлийн явц

- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.

- Хийх гэж буй үйлдлээ танилцуулан зөвшөөрөл авна.
- Эмчлүүлэгчээ зөв байрлуулна.
- Үйлчлүүлэгчийн биеийн бумба тавих хэсгийг ил гаргана.
- Дэрийг цээжин дор тавьж, түрүүлэг нь харуулан 2 гарыг дэрний хоёр талаас тэврүүлэн хэвтүүлнэ.
- Зарим тохиолдолд суугаа байдалд тавьж болно.
- Галтай бумба тавих үед үйлчлүүлэгчийн үсийг боно.
- Арьсыг хуурай болтол арчиж, вазелинаар нимгэн тосолно.
- Төмөр савхны үзүүрт хөвөнг нягт, унахааргүй ороож, бэхлээд, тэр хэсгээ спиртэд сайтар дүрж, илүүдэл спиртийг шахаж гаргана.
- Спиртэй бамбараа асаасан лаан дээр барьж асаагаад, гартаа бумбыг хоёр, хоёроор нь барьж, галаа бумбанд 1-2 секунд орчим хугацаанд оруулсны дараа бумбануудыг маш хурдан арьсан дээр тавьж өгнө.
- Зөв тавьсан тохиолдолд арьс тэр даруйдаа сорогдон улайна. Мөн цаас ашиглаж бумба тавьж болно
- Үйлдлийн явцад үйлчлүүлэгчтэй байнга харилцана.
- Үйлчлүүлэгчээ дулаан хучиж, эмчийн заалтаас шалтгаалан 5-15 минут байлгана.
- Бумбыг авахдаа аль нэг хуруугаараа бумбаны амсар орчим арьсыг зөөлөн дарж, хөндийрүүлэн, хий оруулж авна.
- Бумбыг түмпэнтэй ус руу хийнэ.
- Бумба тавьсан газрыг цэвэр алчуураар арчин, тосолж өгнө.

Үйлдлийн дараа

- Үйлчлүүлэгчид тохирсон зөвлөгөө өгнө.
- Хэрэглэсэн зүйлээ хурааж, хог хаягдлыг ангиллын дагуу устгана.
- Үйлдлийн дараа гарцаа угаана.
- Сувилгааны түүхэнд бичиж тэмдэглэнэ.

Анхаарах зүйлс

- Бумбаны ирмэгийг хэт халааж болохгүй.
- Түлэхээс сэргийлнэ

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

АМЬСГАЛЫН ЗАМ ЧӨЛӨӨЛӨХ

Тодорхойлолт

- Амьсгалын зам чөлөөлөх гэдэг нь эмчлүүлэгч мэдээгүйжүүлгээс сэрэх үед ба маскаар унтуулж байгаа болон ухаангүй үед хэл арагшаа унаж залгиурыг таглаж амьсгалд саад үүсэхээс сэргийлж, үзүүлж буй тусlamж үйлчилгээг хэлнэ.

Зорилго

- Сувилагч сувилахуйн тусlamж үйлчилгээг үйлчлүүлэгчид нэмэлт зовиур үүсгэхгүйгээр мэргэжлийн өндөр түвшинд, хөнгөн, шуурхай үзүүлэх
- Хэл дарагч буюу агааржуулагч гуурсыг үйлчүүлэгч мэдээгүйжүүлгээс сэрэх үед маскаар унтуулж байгаа болон хүнд ухаангүй үед хэл арагшаа унаж залгиурыг таглаж амьсгалд саад үүсэхээс сэргийлэх

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусlamж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Үйлчүүлэгч ухаан алдах
- Бүх биеийн булчин супрах
- Мөгөөрсөн хоолойд бөөлжис, гадны биет орох
- Гэмтлийн улмаас

Эсрэг заалт

- Эмчлүүлэгч ухаантай үед хэл дарагч хэрэглэхгүй
- Амны хөндийн салст буюу хэл уруул гэмтсэн үед
- Хамраас цус гарч байгаа үед

Хэрэглэгдэх зүйлс:

1. Гар ариутгах уусмал
2. Нэрмэл ус
3. Үзлэгийн бэзэлий
4. Амаар тавьдаг хэл дарагч
5. Хог хаягдлын уут сав
6. Сувилгааны түүх
7. Бал

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйвч дээрх мэдээлэлтэй тулгах)

Үйлдлийн явц:

- Гараа угааж, халдаргүйжүүлнэ
- Бээлий өмсөнө
- Эмчлүүлэгчээ тэгш гадаргуу дээр хэвтүүлж амны хөндийд гадны биет байгаа эсэхийг шалгана.
- Нэг гараараа духан дээр дарж, негеэ гараар доод эрүүг дээш өргөнө.
- Нэг гараараа духны дээр дарж негеэ гарын эрхий хурууг аманд хийж эрүүг дээш өргөнө.
- Доод эрүүний түүшиг хоёр гараар дээш өргөх. Энэ арга нь төвөгтөй арга боловч амьсгалын дээд замыг сайн чөлөөлдөг. /амны булангаас доод эрүүний булан хүртэл/
- Агууржуулагч гуурсыг норгоод махир хэсгийт тагнай дагуулан оруулж, 180° эргүүлэн хэлний угруу түлхэж өгнө.
- Эрүү зуурсан тохиолдолд ам тэлэгчийг ашиглан агааржуулагч гуурсыг тавьж болно.
- Агааржуулагч гуурсыг эргүүлсэний дараа эрхий хуруугаар зөвлөн дарж оруулна.

Агааржуулагч гуурсыг хамраар тавих.

- Толгойг гэдийлгэнэ.
- Гуурсыг тосолно.
- Хамрын хөндийг шалгаж цэвэрлэнэ.
- Гуурсыг хамрын нүхэнд тэгш өнцгөөр хийнэ.
- Гуурсийг хуруугаараа зөвлөн дарж оруулна.
- Амны хөндийд шархтай үед хэрэглэхэд тохиромжтой.

Үйлдлийн дараа:

- Үйлчлүүлэгчийн сахиурт зөвлөгөө өгнө. (хэрхэн асаргаа үзүүлэхийг сахиурт зөвлөнө.)
- Хэрэглэсэн зүйлээ хурааж, хог хаягдлыг ангиллын дагуу устгана.
- Үйлдэл хийж дуусаад гарaa угаана.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ.

Анхаарах зүйлс

- Хийх гэж буй үйлдлээ тайлбарлан ойлгуулах
- Үйлдлийг хийж дууссаны дараа тодорхой хугацаанд хянах,
- Тухайн гардан ажилбарыг хийх мэдлэг дутмаг, арга техникийг сайн эзэмшээгүйгээс, хэрэглэгдэх эмийн бодис болон бусад хэрэглэгдэх материалын хүчинтэй хугацаа, зөв хадгалалт, ариун байдал, халдварт хамгааллын дэглэм, эсрэг заалт зөрчигдсөнөөс үйлчлүүлэгчид нэмэлт зовиур, хүндрэл учруулахаас урьдчилан сэргийлж ажиллана.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч:

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч:

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ЦЭР САЛСТ СОРУУЛАХ

Тодорхойлолт

Амьсгалын замд үүссэн цэр, салстыг соруулж амьсгалын замыг чөлөөлөх

Зорилго

- Амьсгалын замыг чөлөөлөх

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Унтуулгын үед амьсгалын замаас салиа гарсан үед
- Таталтын үед
- Ухаангүй эмчлүүлэгчийн амьсгалын зам saatсан үед

Эсрэг заалт

- Хамраас цус гарч байгаа үед

Хэрэглэгдэх зүйлс:

1. Соруулгын аппарат
2. Соруулгын гуурс
3. Нэрмэл ус
4. Бээлий
5. Беөр хэлбэрийн таваг
6. Сальфетик
7. Пульсоксиметр
8. Хог хаягдлын уут
9. Гар халдвартгүйжүүлэх уусмал
10. Сувилахуйн түүх

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйвч дээрх мэдээлэлтэй тулгах)

Үйлдлийн явц:

- Гараа угаана/ халдаргүйжүүлнэ.
- Ухаантай үйлчлүүлэгч байвал хийх үйлдлээ тайлбарлана.
- Бээлий өмсөнө.
- Эмчлүүлэгчээ тэгш гадаргуу дээр хэвтүүлж амны хөндийд гадны биет байгаа эсэхийг шалгана.
- Эмчлүүлэгчий дэргүй хэвтүүлнэ.
- Соруулга хийхийн өмнө 100% O₂ -оор амьсгалуулах ба захын судасны O₂-ийн ханамж хэмжинэ.
- Соруулгын аппаратыг цахилгаанд холbon аппаратын ажиллагааг шалган соруулгын гуурсыг холбоно.
- Зүүн гартаа бээлий өмсөнө.
- Соруулгын гуурсны уутыг бээлийгүй гараараа шувтарч авч бээлийтэй гараар гуурснаас барина.
- Соруулгын гуурсны үзүүрийг чийглэж өгнө.

- Эмчлүүлэгчийн амыг ангайлган соруулгын гуурсыг хийхдээ тагийг таглахгүй хийгээд соруулж эхлэх үед тагийг таглах /амны хөндийн соруулгын гуурсыг 20 сек орчим хийнэ./
- Соруулгын гуурсыг тагласан хэвээр фурациллины уусмалаас соруулж гуурсыг цэвэрлэн дахин соруулгыг хийнэ.
- Цэр салстыг 2-3 удаа соруулна.
- Соруулж дууссаны дараа соруулгын гуурсыг салгаж халдвартгүйжүүлээд /бээлийн дотор хийн/ шар уутанд хийнэ.
- Амыг арчин уруулыг тослоно.
- О2-ийн хангамж SpO2 -ыг хэмжилтийг харна.
- Соруулгын аппаратыг салгаж, зааврын дагуу цэвэрлэж, халдвартгүйжүүлнэ.

Үйлдлийн дараа:

- Үйлчлүүлэгчид эсвэл сахиурт зөвлөгөө өгнө. (хэрхэн асаргаа үзүүлэхийг сахиурт зөвлөнө.)
- Хэрэглэсэн зүйлээ хурааж, хог хаягдлыг ангиллын дагуу устгана.
- Үйлдэл хийж дуусаад гарaa угаана.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ.

Анхаарах зүйлс

- Хийх гэж буй үйлдлээ тайлбарлан ойлгуулах
- Үйлдлийг хийж дууссаны дараа тодорхой хугацаанд хянах,
- Соруулга гуурсыг 1 удаад 20 секундээс илүүгүй хугацаагаар соруулах
- Тухайн гардан ажилбарыг хийх мэдлэг дутмаг, арга техникийг сайн эзэмшээгүйгээс, хэрэглэгдэх эмийн бодис болон бусад хэрэглэгдэх материалын хүчинтэй хугацаа, зөв хадгалалт, ариун байдал, халдварт хамгааллын дэглэм, эсрэг заалт зөрчигдсөнөөс үйлчлүүлэгчид нэмэлт зовиур, хүндрэл учруулахаас урьдчилан сэргийлж ажиллана.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч:

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч:

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ХҮЧИЛТӨРӨГЧ ӨГӨХ

Тодорхойлолт

- Хүчилтөрөгч нь амьсгалж байгаа агаарын найрлаганд хичнээн хэмжээтэй байх тутам, төдий чинээ бие махбодод хүрэлцэхүйц хэмжээтэй хүчилтөрөгч нэвтрэн орох болно. Ердийн амьсгалж байгаа агаарын найрлаганд хүчилтөрөгч - 16.3%, нүүрсхүчлийн хий - 4%, азот - 79.9% байдаг. **Хүчилтөрөгчийг болланоос эсвэл хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппаратнаас өгч болно.**

Зорилго

- Бие махбодын хүчилтөрөгчийн дутагдлыг нехнө.

Хамрах хүрээ

Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Амьсгалын зам чөлөөлөөд үр дүнгүй үед
- Төвийн хөхрөлттэй үед
- Яраглаж амьсалах үед
- Амьсгаадалтыг багасгах
- Цээж хүчтэй хонхолзох
- Тайван байхад захын судасны хүчилтөрөгчийн ханамж **94%-иас** бага

Хэрэглэгдэх зүйлс

1. Хүчилтөрөгч өгөх маск эсвэл ац гуурс
2. Хүчилтөрөгчийн баллон (ханын системээр байж болно)
3. Хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат
4. Хүчилтөрөгчийн баллоны редуктор (урсгалын хурд тохируулагч)
5. Бобров
6. Нэрмэл ус
7. Бээлий
8. Хог хаягдлын уут
9. Гар халдвартгүйжүүлэгч
10. Сувилгааны түүх
11. Бал

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (*Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйч дээрх мэдээлэлтэй тулгах*)

Үйлдлийн явц

- Хэрэглэгдэх зүйлсийг ойр тавина.
- Гараа угааж халдвартгүйжүүлнэ.
- Бээлий өмсөнө.
- Захын судсан дахь хүчилтөрөгчийн ханамжийг пульсоксиметрээр тодорхойлно.
- Хэрэв шууд баллонтой хүчилтөрөгчөөс өгч байгаа үед баллоны нээх хэсгийг онгойлгон баллон доторх хүчилтөрөгчийн хэмжээг шалгана. (Тухайн эмнэлэг хүчилтөрөгчийн ханын системтэй эсвэл хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппаратнаас өгч байгаа тохиолдолд хамаарахгүй.)
- Бобровт нэрмэл усыг заагдсан хэмжээ хүртэл хийж холбоно.
- Тохируулагч редукторын хүчилтөрөгч гарах хэсэгт гуурсийг холбоно.
- Эмчийн заалтын дагуу урсгалын хурдыг тохируулна.
- Маск эсвэл хамрын ац гуурсаар хүчилтөрөгч ирж байгаа эсэхийг шалгаж үйлчлүүлэгчид зүүнэ.
- Шаардлагатай тохиолдолд захын судсан дахь хүчилтөрөгчийг хамнамжийг тасралтгүй байдлаар хянана.
- Бээлийг тайлна

Үйлдлийн дараа

- Хэрэглэсэн зүйлсээ хураана
- Хог хаягдаа ангилан ялгана
- Гараа угаана
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ

Анхаарах зүйлс

- Хүчилтөрөгч өгөх үед амьсгалын замыг чөлөөлөх
- Хүчилтөрөгчийн дамжуулах гуурсыг 72 цаг болоод солих
- Хүчилтөрөгчийг өгөхдөө чийглэж хэрэглэх.
- Хүчилтөрөгчийн урсгалын хурдыг тохируулах
- Галын аюул ослоос сэргийлэх
- Хүчилтөрөгчийн баллонд тостой гарцаар хүрч болохгүй
- Хүчилтөрөгчийн баллоныг гал, цахилгаан зуухнаас 1.5 м зайд байрлуулах
- Нар туссан цонхны харалдаа байрлуулж болохгүй

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ХОДООД УГААХ

Тодорхойлолт

- Ходоод угаах нь бие махбодийн хордлого, ялангуяа амьдралын амин чухал эрхтнүүдэд хор учруулах, тэдгээрийн үйл ажиллагаа хамрахаас хамгаалах сувилахуйн тусламж үйлчилгээ юм.

Зорилго

- Ходоодыг цэвэрлэх
- Ходоодны мэс заслын өмнө хагалгаанд бэлдэх
- Ходоодыг дурандаж шинжлэх
- Төрөл бүрийн хордлогын үед ходоодонд байгаа хорт зүйлсийг гадагш гаргах
- Бие мах бодийг хордлогоос хамгаалж сэргийлэх.

Заалт

- Эмчилгээ
- Оношилгооны

Эсрэг заалт

- Амны хөндийн залгиурын хурц үрэвсэл
- Улаан хоолойн судасны өргөсөлт
- Улаан хоолойн нарийсалт болон хавдар
- Ходоод гэдэсний цус алдалтын үед
- Ходоод химийн бодисоор хүндээр түлэгдсэн зарим тохиолдол
- Жирэмсний сүүлийн сард

Хэрэглэгдэх зүйлс

1. Ходоодны нарийн хаймсуур болон хавчаар
2. Домботой ус / 8-10литр /
3. Бөөр хэлбэрийн таваг
4. Ам зайлх ус
5. Зориулалтын гель
6. Хэл баригч
7. Алчуур буюу сальфетка
8. Хулдаасан хормогч -2 ш
9. Хувин /10л/
10. Сандал
11. Термометр
12. Жаньегийн тариур
13. Наалдуулагч лент
14. Бээлий
15. Амин үзүүэлэлт хэмжих хэрэгсэл
16. Хог хаягдлын сав

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйвч дээрх мэдээлэлтэй тулгах).

Үйлдлийн явц

- Гараа угааж, бээлийгээ өмсөнө.
- Шаардлагатай бол амин үзүүлэлтийг хянана.
- Эмчлүүлэгчид ямар ажилбар хийх зорилгоо танилцуулна.
- Эмчлүүлэгчийг ажилбарт бэлэн эсэхийг асууна.
- Үйлдлийн зорилго, ач холбогдол, явц, гарч болзошгүй хүндрэл, үйлдлийн үед үйлчлүүлэгчийн хүлээх (амьсгалаа хэрхэн удирдах) үүргийн талаар үйлчлүүлэгчид урьдчилан ярьж, ойлгуулсан, таниулсан байна.
- Хиймэл шүдтэй бол авхуулна.
- Эмчлүүлэгчийг түшлэгтэй сандал дээр цэх суулгаж уусмалын температурыг шалгана (20°C – 25°C).
- Өөртөө болон эмчлүүлэгчид хормогч өмсгөн, хүзүүг алчуураар ороож өгнө.
- Эмчлүүлэгчийн гарг бөөр хэлбэрийн таваг, сальфетик бариулна.

- Аягатай уснаас эмчлүүлэгчид балгуулж, амыг зайлцуулан бөөр хэлбэрийн тавганд хийлгэнэ.
- Сувилагч хаймсуурын бүрэн бүтэн байдлыг шалган авч, 10-15 см хэсгээс баруун гартаа барин эмчлүүлэгчийн аманд хаймсуурын үзүүр хэсгийг оруулан хэлний утг тавьж, эмчлүүлэгчийг аажим шүлсээ залгихыг зөвлөнө.
- Залгих хөдөлгөөнийг дагуулан сувилагч түүний амруу хаймсуурыг тэмдэглэсэн 2 дахь хэмжээ (45 -55 см) хүртэл оруулаад, 10 мл хий соруулсан жаньегийн тариурыг холбож ходоодонд орсон эсэхийг шалгана.
- Хаймсуур ходоодонд орсон бол бэхлэж тогтооно.
- Жанегийн тариурын бүлүүрийг аажим хойш татаж, бүлүүрийг их биенээс салгаж авна.
- Жанег эмчлүүлэгчийн өвдөгний түвшинд барьж, жаньегийн хэмжээгээр усыг аажим дүүргэн хийнэ.
- Устай жаньег өргөн эмчлүүлэгчийн толгойноос дээш 25 см зйтай өргөж усыг ходоодонд оруулна.
- Жаньед ялимгүй ус үлдээн түвшинг доошуулахад, ходоодонд байгаа зүйлсийг усны хамт бохирын хувинд гаргана.
- Энэ үйлдлийг хэд хэдэн удаа давтан хийх ба ходоодноос гарах шингэн нь угааж байгаа уусмал өнгөөрөө гартал угаана
- Ходоодыг угааж дуусмагц бэхэлгээг салгаж, хаймсуурыг аажим сугалан авч бохирлоно.
- Эмчлүүлэгчийн амыг зайлцуулан, арчиж цэвэрлэн уруулыг тослоно.
- Эмлчлүүлэгчийн болон өөрийн хормогчийг тайлна.

Үйлдлийн дараа

- Үйлчлүүлэгчийн ор дэвсгэрийг засаж, дулаан хучиж хэвтүүлнэ
- Хэрэглэсэн зүйлээ хурааж, хог хаягдлыг ангиллын дагуу устгана.
- Үйлдэл хийж дуусаад бээлийгээ тайлж, гараа угаана.
- Хийсэн үйлдлийн явц, үр дүнг сувилгааны тэмдэглэлд бичиж тэмдэглэнэ.
- Эргэн хяналт хийж зөвлөгөө өгнө.

Анхаарах зүйлс

- Үйлчлүүлэгчид ходоод угаах тухай сайн хэлж ойлгуулаагүйгээс аиж балмагдах, сандрах
- Гуурс ходоодонд орсон эсэхийг шалгах,
- Халдвартын дэглэм журам баримтлаагүйгээс халдварт өртөх
- Арга техник зөв эзэмшээгүйгээс үйлчлүүлэгчийг чилээх, ядраах, хаймсуурыг буруу залгиулах, бөөлжүүлэх
- Үйлчлүүлэгчид ходоод угаах тухай сайн хэлж ойлгуулаагүйгээс аиж балмагдах, сандрах
- Хиймэл шүдийг аваагүйгээс хахаж цацах зэрэг гарч болзошгүй хүндрэлүүдээс урьдчилан сэргийлэх зүйтэй.

Үйлдлийг гардан гүйцэтгэх:

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч:

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ХАЙМСУУРААР ХООЛЛОХ

Тодорхойлолт

- Хаймсуураар хооллох нь ухаангүй хүнд эмчлүүлэгч, залгих рефлекс алдагдсан, хүүхэд залгих рефлекс дутуу хөгжсөн эсвэл байхгүй, уруул тагнай сэтэрхий төрсөн хүүхэд, улаан хоолой залгиур хэсгийн гэмтэл түлэгдэл, хоол боловсруулах замын эрхтэнүүдэд мэс засал хийлгэсний дараа, тархины болон бусад хүнд гэмтлүүдийн үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ юм.

Зорилго

- Хооллох

Заалт

- Ухаангүй хүнд эмчлүүлэгч
- Залгих рефлекс алдагдсан
- Хүүхэд залгах рефлекс дутуу хөгжсөн эсвэл байхгүй, уруул тагнай сэтэрхий төрсөн
- Улаан хоолой залгиур хэсгийн гэмтэл түлэгдэл
- Хоол боловсруулах замын эрхтэнүүдэд мэс засал хийлгэсний дараах үед
- Тархины болон бусад хүнд гэмтлүүдийн үед

Эсрэг заалт

- Ходоод гэдэсний шархлаа
- Улаан хоолойн судасны өргесөлт, улаан хоолойн нарийсалт
- Ходоод, улаан хоолойн хавдар
- Улаан хоолой хodoодноос цус алдаж байгаа үед
- Жирэмсний сүүлийн сард

Хэрэглэгдэх зүйлс

1. Хаймсуур
2. Хаймсуураар өгөх шингэн хоол /хэмжээ нь 40-200 мл, хэм нь 38-40°C/
3. Шингэн цай, буцалсан ус
4. Жанегийн тариур
5. Ам арчих алчуур /сальфетик/
6. Эрүүн дор тавих алчуур
7. Бөөр хэлбэрийн таваг
8. Бээлий
9. Наалдуулагч лент
10. Хавчаар
11. Чагнуур
12. Гар халдвартгүйжүүлэх уусмал
13. Зориулалтын гель
14. Термометр
15. Хог хаягдлын уут

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйгээ дээрх мэдээлэлтэй тулгах)

Үйлдлийн явцад

- Гараа угааж, халдвартгүйжүүлнэ.
- Эмчлүүлэгчид ямар ажилбар хийх зорилгоо танилцуулна.
- Зөвшөөрөл авна.
- Эмчлүүлэгчийг ажилбарт бэлэн эсэхийг асууна
- Бээлийгээ өмсөнө.
- Хиймэл шүдтэй бол авна.
- Эмчлүүлэгчийн цээжийг 30-45 хэм өндөрлөнө.
- Алчуурыг эрүүн доор нь дэлгэж тавина.
- Хаймсуурын бүрэн бүтэн байдлыг шалган задалж, үзүүрийг 10 см тосолно.
- Хаймсуурын хамрын нүхээр аажим түлхэх хөдөлгөөнөөр 55 см буюу хаймсуурын 2 дах хэмжээ хүртэл оруулаад нөгөө үзүүрт 10 мл хий соруулсан жаньегийн тариурыг холбож ходоодонд орсон эсэхийг шалгана.
- Ходоодонд хаймсуур орсон тохиолдолд бэхлэж тогтооно.

- Жанегийн тариурын бүлүүрийг аажим татаж ходоодны агууламжийг соруулан хаймсуурыг хийгүй болгон таглааг таглана.
- Хаймсуураар хоолпохдоо эхлээд цай, дараа нь хоолыг өгөх ба хоолны /цай, сүү, шөл, ус, шингэн бантан г.м/ температур 36-38 хэмтэй, хоолыг шахахаас өмнө хийг тариурт татаж, үүдэн шүднээс дээш 10- см өргөж аажим шахаж ходоодонд оруулна.
- Тариурт бага зэрэг хоол үлдээж, хаймсуурыг таглана.
- Хооллож дуусмагц бэлдсэн цай, эсвэл буцалсан усыг хаймсуураар хийж өгнө.
- Шаардлагатай тохиолдолд хаймсуурыг авахгүй байж болно.

Үйлдлийн дараа

- Хэрэглэсэн зүйлсээ хурааж, цэвэрлэнэ.
- Бээлийгээ тайлж, гараа угаана.
- Бичиж тэмдэглэнэ.

Анхаарах зүйлс

- Эмчлүүлэгчийн биеийн байдлаас шалтгаалж 1-2 цагийн зйтай 40- 200 мл хоолоор хооллох
- Эмчлүүлэгчийг хооллож дууссаны дараа хаймсуурыг тагласан байх
- Хаймсуураар хэдий хэр хэмжээний, юу гарсныг сайн ажиглаж тэмдэглэсэн байх
- Хаймсуураар хооллох явцад эмчлүүлэгч хамраараа чөлөөтэй амьсгалж байх
- Үүдэн шүднээс 15-20 см дээш түвшинд хоолыг байрлуулж өгөх
- Хаймсуурын ил байгаа хэсэгт хоолны үлдэгдэл үлдээхгүй байх

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч, **туслах сувилагч**

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ЦЭВЭРЛЭХ БУРГУЙ ТАВИХ

Тодорхойлолт

- Цэвэрлэх бургуй нь их хэмжээний шингэнитг биед шахан оруулж гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг цочроосноор, мөн бүдүүн гэдэсний салст бүрхэвчинд хэсэгчилсэн өдөөлт өгч өтгөн гаргалтыг түргэсгэнэ. Цэвэрлэх бургуйн гипертоник шингэн (hypertension solution) ундны ус, физиологийн уусмал изотоник шингэн зэргийг ашигладаг. Гипертоник шингэн нь осмос дараалт өндөртэй тул завсрын шингэнээс усыг бүдүүн гэдэс рүү татаж өгдөг. Үүний үр дүнд бүдүүн гэдэс шингэнээр дүүрч өтгөн гаралт хурдасдаг.

Зорилго

- Хэвлэлийн хөндийн рентген шинжилгээ, мэс засалд ороход гэдсийг цэвэр байлгах, хордлого тайлах

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Эмчийн заалтаар дараах тохиолдлуудад:
- Өтгөн хатсан үед өтгөнийг гадагшлуулах
- Хордлогын үед хордлого тайлах
- Гэдэс ходоодны мэс заслын үед мэс засалд бэлтгэх.
- Бага тааз болон хэвлэлийн хөндийн рентген шинжилгээний өмнө
- Бүдүүн шулуун гэдсийг дурандахын өмнө
- Дуслын болон тэжээлийн бургуй тавихын өмнө

Эсрэг заалт

Сувилагчийн ажиглалт, үнэлгээний үр дүнд тухайн нөхцөл байдлаас үйлчлүүлэгчийн биед гарсан өөрчлөлт, тухайн гардан ажилбарын өвөрмөц эсрэг заалтуудыг анхаарах. Дараах шинж тэмдгүүдийн үед:

- Хоол боловсруулах эрхтэнд хийгдсэн хагалгааны дараах эхний өдөр
- Хоол боловсруулах эрхтнээс цус алдсан үед
- Бүдүүн гэдэсний шархлаа
- Шулуун гэдэсний хавдар
- Тархины даралттай үйлчлүүлэгч
- Жирэмсний бага сартай
- Зүрхний архаг өвчтэй эмчлүүлэгч
- Шулуун гэдэс өвчтэй, хавантай үед
- Мухар олгойн хурц үрэвсэл
- Хошногоны амсрын шархлалт болон цууралт.

Хэрэглэгдэх зүйлс

1. Эсмархийн бургуй сав (1.5- 3 л багтаамжтай)
2. Ариун (нэг удаагийн) хошуу
3. Бөөр хэлбэрийн таваг
4. Бургуйн хошуу тослох вазелин
5. Хулдаас, даавуу
6. Зориулалтын цаасан сальфетик
7. Бээлий
8. Хөтөвч
9. Буцалгаж хөргөсөн бүлээн (биеийн халууны хэмтэй) ус
10. Термометр
11. Штатив
12. Хог хаягдлын сав
13. Хаалт, хөшиг
14. Зориулалтын гель
15. Хог хаягдлын уут

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйч дээрх мэдээлэлтэй тулгах)

Үйлдлийн явц:

- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Урьд нь бургуй тавиулж байсан эсэхийг асууна
- Бургуй тавиулж байгаагүй бол тайлбарлаж ойлгуулаад шингэнийг биед шахаж оруулахад үүсэх эвгүй мэдрэмж, урьдчилан сэргийлэх арга зам, тохиромжтой байрлал зэргийг тайлбарлаж өгөх
- Эмчийн бичсэн эмчилгээний заалтыг эмчилгээний хуудастай тулгаж шалгана.
- Хаалт хөшиг татна.
- Бээлий өмсөнө.
- Эмчлүүлэгчийг зөв байрлуулна. Ингэхдээ эмчлүүлэгчийг түүний орыг ирмэгдүүлэн зүүн хажуугаар нь харуулж, баруун хөлийг хагас нугалуулан хэвтүүлнэ.
- Дэвсгэрийг бохирдооос сэргийлж, үйлчлүүлэгчийн өгзгөн доогуур хулдаас даавуу дэвсэж өгнө.
- Эмчлүүлэгчийн өгзгийг орны ирмэг рүү болгоно.
- Бэлтгэсэн усаа эсмархад хийж, штативт байрлуулна.
- Бургуйн хошууг авч, гуурсны үзүүрт холбон тосолно.
- Зүүн гарын 1, 2 дугаар хуруугаар хошногоны амсрыйг 2 тийш нь тэлж, баруун гараараа бургуйны хошууг шулуун гэдэс рүү оруулахдаа хүйсний чиглэлд 3- 4 см, нурууны чиглэлд 2- 3 см, нийт 7 см орчим оруулна.
- Хавчаарыг авч усыг зохих хэмээр гоожуулна.
- Эмчлүүлэгчийг гэдсээ суллаж, гүнзгий амьсгал авахыг зөвлөнө.
- Шулуун гэдсэнд ус орж дуусах үед хавчаарыг хааж, бургуйн хошууг сугалж авна.
- Эмчлүүлэгчийг 5-10 минут хийсэн шингэнийг барихыг зөвлөнө.
- Хэрэв хэвтрийн үйлчлүүлэгч байвал хөтөвч тавьж өгөөд, дараа нь угаалга хийнэ.

Үйлдлийн дараа:

- Эмчлүүлэгчийн гадагшлуулсан зүйлд хяналт тавина.
- Бээлийгээ тайлна.
- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Эмчлүүлэгчийн ор дэвсгэрийг засаж, дулаан хучиж хэвтүүлнэ
- Амбулаториор ирж үйлчлүүлсэн тохиолдолд хэсэг хугацаанд ажиглаж байгаад явуулна
- Хэрэглэсэн зүйлээ хурааж, хог хаягдлыг ангиллын дагуу устгана.
- Үйлдэл хийж дуусаад гараа угаана.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ.
- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэн тохирох арга хэмжээг авна.

Анхаарах зүйлс

- Цэвэрлэх бургуй тавих эсрэг заалтуудыг зөрчсөнөөс гарах хүндрэл
- Цэвэрлэх бургуй тавих усны хэм таараагүйгээс гэдэсний салст бүрхэвчийг түлэх, цочроох
- Бургуйн хошууг тослоогүйгээс шулуун гэдэсний салстыг цочроох, гэмтээх
- Арга техникийг буруу эзэмшсэнээс гэдсэнд хий оруулах
- Гадна хунигч булчингийн агшилтгүй үйлчлүүлэгчид бургуй тавихдаа хөтөвч дээр хэвтүүлэх ба шаардлагатай бол орны толгойг бага зэрэг өндөрсгөн эмчлүүлэгчийн толгойд дэр ивж бургуйг тавина.
- Ходоодны болон эмэгтэйчүүдийн мэс засал хийлгэсэн тохиолдолд оёдол задрах магадлалтай тул болгоомжлох.
- Цусны даралт, шингэний хордлого, булчингийн гэмтэл ба үхжил, цусан дахь кальцийн хэмжээ ихсэх, хэм алдагдах зэрэг асуудал үүсэх буюу их хэмжээний бургуйн шингэн биед шахаж оруулахад шархлаа үүсэх, цус алдах зэрэг эрсдэлтэй..
- Үйлдлийг эмчлүүлэгчийн өрөөнд хийсэн тохиолдолд эмчлүүлэгчийн хувийн эрхийг хүндэтгэх үүднээс ор тусгаарлагчийг сайтар татаж, хэрвээ эмчлүүлэгч хүссэн тохиолдолд тусгай ажилбарын өреөнд үйлдлийг гүйцэтгэж болно.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ДУСЛЫН БУРГҮЙ ТАВИХ

Тодорхойлолт

- Эмчлэх, хооллох зорилгоор эмийн болон **ШИМ ТЭЖЭЭЛТ ХООЛЫГ** шулуун гэдсэнд дуслаар оруулах ажилбарыг хэлнэ.

Зорилго

- Хооллолт
- Эмчилгээний

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Эмчийн заалтаар дараах тохиолдлуудад:
- Эмчлүүлэгч амаар хооллох, шингэн уулгах боломжгүй үед
- Хodoодны салстыг цочроо өндөр үйлчилгээтэй эмийн бодис хэрэглэж байгаа үед
- Шингэн алдалтын үед
- Уналт таталтын үед тайвшруулан, таталтыг багасган эмчлэх

Эсрэг заалт

Сувилагчийн ажиглалт, үнэлгээний үр дүнд тухайн нөхцөл байдлаас үйлчлүүлэгчийн биед гарсан өөрчлөлт, тухайн гардан ажилбарын өвөрмөц эсрэг заалтуудыг анхаарах. Дараах шинж тэмдгүүдийн үед:

- Хоол боловсруулах эрхтнээс цус алдсан үед
- Бүдүүн гэдэсний шархлааны үед
- Шулуун гэдэсний урвах эмгэгийн үед
- Мухар олгойн хурц үрэвсэлийн үед
- Хошногоны амсрын шархлалт болон цууралтын үед.
- Шулуун гэдэсний хортой, хоргүй хавдарын үед

Хэрэглэгдэх зүйлс

1. Шулуунд гэдсэнд тавих гуурс
2. Эмийн бодис, уусмал
3. Дуслын систем
4. Бөөр хэлбэрийн таваг
5. Бургуйн хошуу тослох вазелин
6. Дэвсэх хулдаас, даавуу
7. Бээлий
8. Наалдуулагч лент
9. Зориулалтын гель
10. Термометр
11. Хормогч
12. Ариун цэврийн цаас
13. Гар халдвартгүйжүүлэх уусмал
14. Хөтөөвч /шаардлагатай бол/
15. Хог хаягдлын сав
16. Штатив
17. Хаалт, хөшиг
- 18.

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйөч дээрх мэдээлэлтэй тулгах)

Үйлдлийн явц:

- Гараа угаах/халдвартгүйжүүлнэ.
- Хийх үйлдлээ тайлбарлана.
- Зөвшөөрөл авна.
- Эмчлүүлэгчийг ажилбарт бэлэн эсэхийг асууна.
- Эмчийн бичсэн эмчилгээний заалтыг эмчилгээний хуудастай тулгаж шалгана.
- Хаалт хөшиг татна.
- Бээлий өмсөнө.

- Эмчлүүлэгчийг зөв байрлуулна. Ингэхдээ эмчлүүлэгчийг түүний орыг ирмэгдүүлэн зүүн хажуугаар нь харуулж, баруун хөлийг хагас нугалуулан хэвтүүлнэ.
- Дэвсгэрийг бохирдооос сэргийлж, үйлчлүүлэгчийн өгзгөн доогуур хулдаас даавуу дэвсэж өгнө.
- Эмчлүүлэгчийн бөгзгийг орны ирмэг рүү болгоно.
- Бэлтгэсэн шингэний хэмийг шалгана
- Бэлтгэсэн шингэнээ дуслын системд угсарч залгахад бэлтгэнэ
- Дуслын бургуй тавих гуурсаа авч үзүүрийг нь тослоно
- Гуурсаа шулуун гэдэс рүү 15 см орчим зөөлөн оруулна.
- Шингэнийг 1 минутанд 40-60 удаа дусахаар тохируулан, гуурсыг наалдуулагч лентээр бэхэлж өгнө.
- Бургуйг ойр ойрхон хянана
- Бургуй тавьж дуусмагц гуурсыг болгоомжтой сугалан авна

Үйлдлийн дараа:

- Хэрэглэсэн зүйлсээ хураана
- Бээлийгээ тайлж гараа угаана
- Үйлчлүүлэгчийн дэвсгэрийг засаж, дулаан хучиж хэвтүүлнэ
- Эмчлүүлэгчийн ор дэвсгэрийг засаж, дулаан хучиж хэвтүүлнэ
- Амбулаториор ирж үйлчлүүлсэн тохиолдолд хэсэг хугацаанд ажиглаж байгаад явуулна
- Хэрэглэсэн зүйлээ хурааж, хог хаягдлыг ангиллын дагуу устгана.
- Үйлдэл хийж дуусаад бээлийгээ тайлж, гараа угаана.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ.
- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэн тохирох арга хэмжээг авна.

Анхаарах зйүлс

- Бургуйн хошууг заавал тослох
- Гэдсэнд хий оруулахгүй байх
- Дуслын бургуйг тавихын өмнө цэвэрлэх бургуй тавьж, бие засуулах
- Бургуйн дуслах тоог үйлчлүүлэгчийн наснаас нь хамаарч тохируулах
- Хийж байгаа шингэнээ бүлээнээр нь хийх
- Үйлдлийг эмчлүүлэгчийн өрөөнд хийсэн тохиолдолд эмчлүүлэгчийн хувийн эрхийг хүндэтгэх үүднээс ор тусгаарлагчийг сайтар татаж, хэрвээ эмчлүүлэгч хүссэн тохиолдолд тусгай ажилбарын өрөөнд үйлдлийг гүйцэтгэж болно.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

БИЧИЛ БУРГУЙ ТАВИХ

Тодорхойлолт

- Тос болон эмийн бодисыг биед оруулан гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг сайжруулж, өтгөнийг зөвлөхүүлэн гаргах нөхцөлийг бүрдүүлж, шулуун гэдэс, хошногоны амсрыг зөвлөн өтгөн гаргалтыг хурдасгадаг ба гэдэсний дүүрэлтийг намдаахад оршино.

Зорилго

- Гэдэс цэвэрлэх

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Өтгөн хатсан үед өтгөнийг гадагшлуулах
- Гэдэс хodoодны мэс заслын үед мэс засалд бэлтгэх.
- Мухар олгойн хурц үрэвслийн үед
- Гэдэс дотор болон, шулуун гэдэсний үрэвслийн шинж тэмдэгтэй
- Амаржихын өмнө

Эсрэг заалт

Сувилагчийн ажиглалт, үнэлгээний үр дүнд тухайн нөхцөл байдлаас үйлчлүүлэгчийн биед гарсан өөрчлөлт, тухайн гардан ажилбарын өвөрмөц эсрэг заалтуудыг анхаарах. Дараах шинж тэмдгүүдийн үед:

- Хоол боловсруулах эрхтнээс цус алдсан үед
- Гэдэс дотрын өвчин болон шархтай хүн
- Хүнд сэтгэл мэдрээлийн өвчтэй хүнд
- Хүнд хэлбэрийн гэдэсний өвчин, гэдэс мушгих, бөөлжих, дотор муухайрах хodoодны хурц хэлбэрийн өвдөлтийн үед
- Шулуун гэдэснээс цус алдаж байгаа үед

Хэрэглэгдэх зүйлс

1. Зориулалтын тос эсвэл **20 ml тосон бургуй**
2. Беөр хэлбэрийн таваг
3. Хулдаас, даавуу
4. Цаасан сальфетик
5. Бээлий
6. Хөтөвч
7. Хаалт, хөшиг
8. Хог хаягдлын сав

Үйлдлийн технологи

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуйгээ дээрх мэдээлэлтэй тулгах)

Үйлдлийн явц:

- Гараа угаана/халдвартгуйжүүлнэ.
- Хийх үйлдлээ тайлбарлан ойлгуулна.
- Зөвшөөрөл авна.
- Эмчлүүлэгчийг ажилбарт бэлэн эсэхийг асууна.
- Эмчийн бичсэн эмчилгээний заалтыг эмчилгээний хуудастай тулгаж шалгана.
- Хаалт хөшиг татна.
- Бээлий өмсөнө.
- Эмчлүүлэгчийг зөв байрлуулна. Ингэхдээ эмчлүүлэгчийг түүний орыг ирмэгдүүлэн зүүн хажуугаар нь харуулж, баруун хөлийг хагас нугалуулан хэвтүүлнэ.
- Дэвсгэрийг бохирдохоос сэргийлж, үйлчлүүлэгчийн өгзгөн доогуур хулдаас даавуу дэвсэж өгнө.
- Эмчлүүлэгчийн өгзгийг орны ирмэг рүү болгоно.
- Бургуйн хошууг авч, гуурсны үзүүрт холбон тосолно.
- Зүүн гарын 1, 2 дугаар хуруугаар хошногоны амсрыг 2 тийш нь тэлж, баруун гараараа бургуйны хошууг шулуун гэдэс рүү оруулахдаа хүйсний чиглэлд 3- 4 см, нурууны чиглэлд 2- 3 см, нийт 7 см орчим оруулна.
- Эмчлүүлэгчийг гэдсээ суллаж, гүнзгий амьсгал авахыг зөвлөнө.

- Шулуун гэдсэнд ус орж дуусах үед хавчаарыг хааж, бургуйн хошууг сугалж авна.
- Эмчлүүлэгчийг 5-10 минут хийсэн шингэнийг барихыг зөвлөнө.
- Хэрэв хэвтрийн үйлчлүүлэгч байвал хөтөвч тавьж өгөөд, дараа нь угаалга хийнэ.

Үйлдлийн дараа:

- Эмчлүүлэгчийн гадагшлуулсан зүйлд хяналт тавина.
- Бээлийгээ тайлж, гарaa угаана.
- Эмчлүүлэгчийн ор дэвсгэрийг засаж, дулаан хучиж хэвтүүлнэ
- Амбулаториор ирж үйлчлүүлсэн тохиолдолд хэсэг хугацаанд ажиглаж байгаад явуулна
- Хэрэглэсэн зүйлээ хурааж, хог хаягдлыг ангиллын дагуу устгана.
- Үйлдэл хийж дуусаад гарaa угаана.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ.
- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэн тохирох арга хэмжээг авна.

Анхаарах зүйлс

- Тосон бургуй тавих эсрэг заалтуудыг зөрчсөнөөс гарах хүндрэл
- Хэт эмзэг мэдрэмтгий, цочромтгой, тууралт гарсан үед болон шинж тэмдэг илэрсэн үед
- Бага насны хүүхдэд хэрэглэж байгаа үед эцэг эх асран хамгаалагч нь хамт байгаа үед

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ХИЙ ГАРГАХ ГУУРС ТАВИХ

Тодорхойлолт

- Эмчилгээний болон зовиур багасгах зорилгоор шулуун гэдсэний хий гаргах ажилбарыг хэлнэ.

Зорилго

- Бүдүүн гэдсэнд хуралдсан хийг гадагшлуулах, гэдэсний дүүрэнгийг багасгах зорилгоор хий гаргах гуурс тавина.

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Бүдүүн, нарийн гэдэс хийгээр дүүрсэн үед
- Үйчлүүлэгчийн зовиурыг хөнгөвчлөх
- Эм уугаад гэдэсний дүүрэнгэ дарагдахгүй байх

Эсрэг заалт

Сувилагчийн ажиглалт, үнэлгээний үр дүнд тухайн нөхцөл байдлаас үйлчлүүлэгчийн биед гарсан өөрчлөлт, тухайн гардан ажилбарын өвөрмөц эсрэг заалтуудыг анхаарах. Дараах шинж тэмдгүүдийн үед:

- Хоол боловсруулах эрхтэн, шулуун гэдэснээс цус алдсан үед
- Шулуун гэдэсний хортой, хоргүй хавдар
- Хошногоны амсрын шархдалт, цууралт, хагаралт

Хэрэглэгдэх зүйлс

1. Шулуун гэдсэнд тавих гуурс /хатуу ханатай нарийхан гуурс/
2. Дэвсэх хулдаас, даавуу
3. Бөөр хэлбэрийн таваг
4. Зориулалтыг гель
5. Наалдуулагч лент
6. Хулдаас, даавуу
7. Ариун цэврийн цаас
8. Устай шил
9. Бээлий
10. Хаалт, хөшиг
11. Хог хаягдлын сав

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуүвеч дээрх мэдээлэлтэй тулгах)

Үйлдлийн явц:

- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Хийх үйлдлээ тайлбарлана.
- Зөвшөөрөл авна.
- Эмчлүүлэгчийг ажилбарт бэлэн эсэхийг асууна.
- Эмчийн бичсэн эмчилгээний заалтыг эмчилгээний хуудастай тулгаж шалгана.
- Хаалт хөшиг татна.
- Бээлий өмснө.
- Эмчлүүлэгчийг зөв байрлуулна. Ингэхдээ эмчлүүлэгчийг түүний орыг ирмэгдүүлэн зүүн хажуугаар нь харуулж, баруун хөлийг хагас нугалуулан хэвтүүлнэ.
- Дэвсгэрийг бохирдооос сэргийлж, үйлчлүүлэгчийн өгзөг доогуур хулдаас даавуу дэвсэж өгнө.
- Эмчлүүлэгчийн өгзгийг орны ирмэг рүү болгоно.
- Гуурсны үзүүрийг тослож, шулуун гэдэс рүү 15-20 шаардлагатай хүнд (20-30) см хүртэлх хэмжээгээр оруулан, хий гаргах гуурсны төгсгөлийг шилтэй усанд дүрнэ.
- Хий гарч байвал устай шилэнд хийн бөмбөлөг үүснэ.
- Үйлдлийг хийх явцад эмчлүүлэгчид байнга ажиглалт хийнэ.
- Хий гаргах гуурсыг тодорхой хугацаанд /15-30 мин/ тавьж, гуурсийг зөвлөн суглаж авна.

Үйлдлийн дараа:

- Бээлийгээ тайлна.
- Эмчлүүлэгчийн ор дэвсгэрийг засаж, дулаан хучиж хэвтүүлнэ
- Амбулаториор ирж үйлчлүүлсэн тохиолдолд хэсэг хугацаанд ажиглаж байгаад явуулна
- Хэрэглэсэн зүйлээ хурааж, хог хаягдлыг ангиллын дагуу устгана.
- Үйлдэл хийж дуусаад гарaa угаана.
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ.
- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэн тохирох арга хэмжээг авна.

Анхаарах зүйлс

- Гуурсны үзүүрийг тослоогүйгээс шулуун гэдэсний салстыг гэмтээх
- Хий гаргах гуурсыг удаан хугацаагаар тавьснаас гэдэсний салст бүрхэвчийг гэмтээх
- Гэдэс цоорох хүндрэл гарах
- Үйлдлийг эмчлүүлэгчийн өрөөнд хийсэн тохиолдолд эмчлүүлэгчийн хувийн эрхийг хүндэтгэх үүднээс ор тусгаарлагчийг сайтар татаж, хэрвээ эмчлүүлэгч хүссэн тохиолдолд тусгай ажилбарын өрөөнд үйлдлийг гүйцэтгэж болно.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ЭМЧЛҮҮЛЭГЧИД БАЙНГЫН ШЭЭЛГҮҮР ТАВИХ

Тодорхойлолт

- Шээлгүүрийг голдуу латексаар хийсэн байдаг. Гэвч хэт мэдрэгшил, харшлын нөлөө үзүүлэх нь ихэсч байгаа тул силикон шээлгүүр хэрэглэх.

Зорилго

- Шээлгүүр тавих ажилбарыг оношилгоо, эмчилгээний зорилгоор тавина.

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Шээсний задгайрал (мэдрэлийн системийн өвчлөлтэй холбоотой)
- Архаг шээс хаагдсан тохиолдолд давсганд хуримтлагдсан шээсийг гадагшлуулах
- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд
- Шээс хаагдах

Эсрэг заалт

- Давсагны хурц үрэвсэл
- Давсагнаас цус алдах
- Давсагны хорт хавдар
- Шээсний сүв нарийсал
- Фимоз

Хэрэглэгдэх зүйлс (Шээлгүүрийн багц)

1. Гар халваргүйжүүлэх уусмал
2. Үзлэгийн бээлий 2
3. Ариун бээлий 1
4. Ариун шарик
5. Тохирсон шээлгүүр
6. 2.5%-ийн повидон иод
7. Шээсний уут
8. Тариур 5,10мл
9. Наалдуулагч лент
10. Лидокайны гель
11. Бөөр хэлбэрийн таваг 2
12. Ариутгасан багаж (хямсаа)
13. Нүхтэй даавуу
14. Хулдаас
15. Хөтөвч
16. Хаалт, хөшиг
17. Хог хаягдлын уут

Үйлдлийн дараалал

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуүвч дээрх мэдээлэлтэй тулгах)

Үйлдлийн явц:

- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Эмчлүүлэгчийг ажилбарт бэлэн эсэхийг асууна.
- Зөвшөөрөл авна.
- Эмчийн бичсэн эмчилгээний заалтыг эмчилгээний хуудастай тулгаж шалгана.
- Хаалт хөшиг татна.
- Бээлий өмсөнө.
- Эмчлүүлэгчийн 2 хелийг өвдгөөр нугалж дээш харуулан хэвтүүлнэ.
- Өгзэгийг өргөж, хулдаас жийрэг даавууг өгзгэн доогуур дэвсэж өгнө.
- Хэрэглэгдэх зүйлсийн /багцын/ бүрэн бүтэн байдал, хүчинтэй хугацааг танилцуулна.
- Ариун хэрэглэгдэх зүйлсийг задлан эмчлүүлэгчийн 2 хөлний завсар байрлуулна.
- Үзлэгийн бээлийг зүүн гартаа өмсөж, бөөр хэлбэрийн тавгийг байрлуулах / багцын бохирын сав/

- Хямсаа болон хавчаараар халдвартгүйжүүлэх уусмал / тамедин шингээсэн шарик авч гадна бэлэг эрхтэн их уруул, бага уруулыг дээрээс нь доош чиглэлтэй, шээний сувийг халдвартгүйжүүлэнэ. / 5 шарик багадаа/
- Хэрэв эрэгтэй эмчлүүлэгч бол шээний сувнээс тойрог хэрбэртэйгээр бэлэг эрхтэнийг халдвартгүйжүүлнэ. / 3 шарик багадаа/
- Үзлэгийн бээлийг тайлж, гарaa халдвартгүйжүүлнэ.
- Ариун бээлийг өмснө.
- Ариун нүхтэй даавууг бэлэг эрхтэнд тааруулж байрлуулна.
- Бөөр хэлбэрийн таваг зөв байрлуулна. Халдвартгүйжүүлэх уусмалыг задлаж бэлтгэнэ.
- Хямсаа болон хавчаараар хадваргүйжүүлэгч уусмал /тамедин/ хадваргүйжүүлэгч уусмал шингээсэн шарикаас авч гадна бэлэг эрхтэнг их уруул, бага уруулыг дээрээс нь доош чиглэлтэй, шээний сувийг халдвартгүйжүүлнэ. / 5 шарик багадаа/
- Хэрэв эрэгтэй эмчлүүлэгч бол шээний сувнээс тойрог хэлбэртэйгээр бэлэг эрхтэнийг халдвартгүйжүүлнэ. /3 шарик багадаа/
- Тохирох шээлгүүрийг сонгон авч зөв барьж, шээний ууттай холбоно.
- Эмчлүүлэгчийг тайван байж, гүнзгий амьсгал авахыг зөвлөнө.
- Шээлгүүрийн үзүүрийг лидокайнтай гель-ээр чийглэн шээний сувээр дамжуулан давсганд оруулна. / эмэгтэйд 4-6 см, эрэгтэйд 22-25 см/
- Шээний уутанд шээс гарч эхэлмэгц тариурт бэлтгэгдсэн физиологийн уусмалыг шээлгүүрт холbon шээлгүүрийг хийж бэхэлнэ. / 5-10 мл/
- Шээлгүүрийг эмчлүүлэгчийн гуяны дунд дээд хэсэгт нь наалтаар бэхэлнэ.
- Шээний уутыг газраас 20 см зйтай өвдөгний түвшинд орноос өлгнө.

Үйлдлийн дараа:

- Эмчлүүлэгчийн шээлгүүрээр гарсан шээсэнд хяналт тавина.
- Бээлийгээ тайлна.
- Хэрэглэсэн зүйлээ хурааж, хог хаягдлыг ангиллын дагуу устгана.
- Үйлдэл хийж дуусаад гарaa угаана.
- Эмчлүүлэгчийн ор дэвсгэрийг засаж, дулаан хучиж хэвтүүлнэ
- Амбулаториор ирж үйлчлүүлсэн тохиолдолд хэсэг хугацаанд ажиглаж байгаад зөвлөгөө өгч явуулна
- Тохирсон зөвлөгөөг өгнө.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ. Ялгарсан шээний хэмжээ, байдлын талаар сувилгааны картанд тэмдэглэнэ.
- Өөрчлөлт илэрвэл эмчид мэдэгдэн тохирох арга хэмжээг авна.

Анхаарах зүйлс

- Шээний сув гэмтээх, өгсөх замаар халдварт орохоос сэргийлэх
- Шээний сувийг гэмтээнээс давсагнаас цус алдах
- Шээлгүүрийг тослоогүй хийснээс салст бүрхэвчийг гэмтэх
- Хагалгаанд орсон бол эхний өдөр шээсээр цус гарч аажим багасах
- Шээлгүүрийн хэмжээ тохироогүйгээс шээний сувээр хатгаж өвдөх, сувний хажуугаар шээс дусагнах
- Хийлсэн бөмбөлгийн улмаас шээх гэж байгаа юм шиг мэдрэмж төрөх
- Шээлгүүр тавьсан боловч шээс гарахгүй байх
- Шээний уутны холбогч хэсэг салах эсвэл супарснаас шээс гоожиж дэвсгэр ногж тавгүйрхэх
- Шээний сувээр цус шүүс, ялгаран орчныг бохирдуулах, халдварт орох
- Үйлчлүүлэгчид давсаг чинэрэх мэдрэмж төрөх
- Шээлгүүрээр идээ, цус гарсан байх, шээлгүүр битүүрэх
- Үйлдлийг үйлчлүүлэгчийн өрөөнд хийсэн тохиолдолд үйлчлүүлэгчийн хувийн эрхийг хүндэтгэх үүднээс ор тусгаарлагчийг сайтар татна, хэрвээ үйлчлүүлэгч хүссэн тохиолдолд тусгай ажилбарын өрөөнд үйлдлийг гүйцэтгэж болно.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

ЭМЧЛҮҮЛЭГЧИД ШЭЭЛГҮҮР ТАВЬЖ ШЭЭС ШИНЖИЛГЭЭНД АВАХ

Тодорхойлолт

- Эмчлүүлэгчийн давсганд шээлгүүр тавьж шээс шинжилгээнд авах ажилбарыг оношилгоо, эмчилгээний зорилгоор тавих ба өгсөх замаар халдварт орохос сэргийлж ажилбарыг гүйцэтгэнэ.

Зорилго

- Эмчилгээ ба оношилгооны

Хамрах хүрээ

- Эмнэлгийн тусламж үзүүлж буй амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг

Заалт

- Шээс шинжилгээнд авах
- Шээс ялгаруулах зам болон аарцгийн хөндийн мэс заслын үед
- Цочмог шээс хаагдалт

Эсрэг заалт

- Шээсний сувгийн гэмтэл
- Шээсний сувний амсарт цус илэрсэн тохиолдолд

Хэрэглэгдэх зүйлс: (Шээлгүүрийн багц)

1. Гар халваргүйжүүлэх уусмал
2. Үзлэгийн бээлий 2
3. Ариун бээлий 1
4. Ариун шарик
5. Тохирсон шээлгүүр
6. 2.5%-ийн повидон иод
7. Шээс шинжилгээнд авах тагтай ариун сав
8. Лидокайны гель
9. Бөөр хэлбэрийн таваг 2
10. Ариутгасан багаж (хямсаа)
11. Нүхтэй даавуу
12. Жийрэг хулдаас
13. Хөтөвч
14. Хаалт, хөшиг

Үйлдлийн технологи

Үйлдлийн өмнө:

- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, бүрэн бүтэн, бэлэн байдлыг шалгана.
- Эмчлүүлэгчтэй мэндэлж, өөрийнхөө нэр албан тушаалыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулна (Овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар асуух, гарын бугуүич дээрх мэдээлэлтэй тулгах)

Үйлдлийн явц:

- Гараа угаана/халдвартгүйжүүлнэ.
- Хийх үйлдлээ тайлбарлана.
- Зөвшөөрөл авна.
- Эмчлүүлэгчийг ажилбарт бэлэн эсэхийг асууна.
- Эмчийн бичсэн эмчилгээний заалтыг эмчилгээний хуудастай тулгаж шалгана.
- Хаалт хөшиг татна.
- Бээлий өмсөнө.
- **Эмчлүүлэгчийн 2 хелийг өвдгөөр нутгалж дээш харуулан хэвтүүлнэ.**
- Өгзэгийг өргөж, хулдаас жийрэг даавууг өгзгэн доогуур дэвсэж өгнө.
- Хэрэглэгдэх зүйлсийн / багцын/ бүрэн бүтэн байдал, хүчинтэй хугацааг танилцуулна.
- Ариун хэрэглэгдэх зүйлсийг задлан эмчлүүлэгчийн 2 хөлний завсар байрлуулна.
- Үзлэгийн бээлийг зүүн гартаа өмсөж, бөөр хэлбэрийн тавгийг байрлуулах /багцын бохирын сав/
- Хямсаа болон хавчаараар халдвартгүйжүүлэх уусмал /тамедин шингээсэн шариаас авч гадна бэлэг эрхтэн их уруул, бага уруулыг дээрээс нь доош чиглэлтэй, шээсний сувийг халдвартгүйжүүлнэ. / 5 шарик багадаа/
- Хэрэв эрэгтэй эмчлүүлэгч бол шээсний сувнээс тойрог хэлбэртэйгээр бэлэг эрхтэнийг халдвартгүйжүүлнэ. /3 шарик багадаа/
- Үзлэгийн бээлийг тайлж, гараа халдвартгүйжүүлнэ.
- Ариун бээлийг өмсөнө.

- Ариун нүхтэй даавууг бэлэг эрхтэнд тааруулж байрлуулна.
- Бөөр хэлбэрийн таваг зөв байрлуулна. Халдвартгүйжүүлэх уусмалыг задлаж бэлтгэнэ.
- Хямсаа болон хавчаараар хадваргүйжүүлэгч уусмал /тамедин/ хадваргүйжүүлэгч уусмал шингээсэн шарикаас авч гадна бэлэг эрхтэнг их уруул, бага уруулыг дээрээс нь доош чиглэлтэй, шээсний сүвийг халдвартгүйжүүлнэ. / 5 шарик багадаа/
- Хэрэв эрэгтэй эмчлүүлэгч бол шээсний сүвнээс тойрог хэлбэртэйгээр бэлэг эрхтэнийг халдвартгүйжүүлнэ. /3 шарик багадаа/
- Тохирох шээлгүүрийг сонгон авч зөв барьж, шээсний ууттай холбоно.
- Эмчлүүлэгчийг тайван байж, гүнзгий амьсгал авахыг зөвлөнө.
- Шээлгүүрийн үзүүрийг лидокайнтай гель-ээр чийглэн шээсний сүвээр дамжуулан давсанд оруулна. / эмэгтэйд 4-6 см, эрэгтэйд 22-25 см/
- Шээс гарч эхэлмэгц эхний шээсийг бөөр хэлбэрийн тавганд авна.
- Шээсний дунд хэсгээс шээсний шинжилгээний саванд авна
- Үлдэгдэл шээсийг хөтөвчинд авна.
- Шээсийг авч дуусаад шээлгүүрийг зөөлөн сугалан авна.

Үйлдлийн дараа:

- Хог хаягдлыг зөв ангилж хаяна.
- Хэрэглэсэн зүйлээ хурааж цэвэрлэнэ.
- Бээлийгээ тайлж гарaa угаана.
- Эмчлүүлэгчид тохирсон зөвлөгөө өгнө.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ.
- Шээсийг шинжилгээнд өгнө.

Анхаарах зүйлс

- Шээсний сүв гэмтээх, өгсөх замаар халдвар орохоос сэргийлэх
- Шээлгүүрийг тослоогүй хийснээс салст бүрхэвчийг гэмтэх
- Үйлдлийг үйлчлүүлэгчийн өрөөнд хийсэн тохиолдолд үйлчлүүлэгчийн хувийн эрхийг хүндэтгэх үүднээс ор тусгаарлагчийг сайтар татна, хэрвээ үйлчлүүлэгч хүссэн тохиолдолд тусгай ажилбарын өрөөнд үйлдлийг гүйцэтгэж болно.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч

- Сувилагч, эх баригч, бага эмч

Үйлдлийн гүйцэтгэлд хяналт тавигч

- Сувилагч, эх баригч, бага эмч, ахлах сувилагч, эмч

Ашигласан эх сурвалж

1. Эрүүл мэндийн технологи, Эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлүүд, MNS-4621-2008 стандарт
2. Д.Дуламсүрэн нарын Сувилгааны гардан ажилбарын гарын авлага, ХСҮТ, Жайка олон улсын байгууллага, УБ хот, 2013
3. Л. Цогзолмаа нарын Сувилгааны гардан ажилбарын гарын авлага, Жайка олон улсын байгууллага, УБ хот, 2017
4. Б. Батсүх нарын Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн сургалтанд зориулсан гардан үйлдлийн гарын авлага, Жайка олон улсын байгууллага, УБ хот, 2020
5. Л.Хишигдэлгэр нарын Сувилахуйн түгээмэл хэрэглэгддэг гардан ажилбарууд, УБ хот, 2022
6. Bedside nursing techniques in medicine and surgery. 1964y, Philadelphia and London
7. Taylor's Clinical nursing skills. second edition 2005y, U.S.A, Pennsylvania
8. Taylor's Handbook of clinical nursing skills. second edition 2015y, U.S.A, Philadelphia
9. 看護技術 プラクティス 第3版。2014年8月。日本 (Сувилахуйн гардан ур чадвар. З дах хэвлэл. 2014 он, Япон)
10. Mosby's Textbook for Nursing Assisstant, Sheila A. Sorrentino, third edition, USA, 1991
11. "Female Urethral Catheterization"Rafael Ortega, MD., Linda Ng, M., Pavan Sekhar, B.S., and Micheal Song, M.A.
12. Дотрын өвчин судлал, Б. Гомбосүрэн, III хэвлэл, УБ хот, 2013
13. Сувилахуйн үндэс, Д. Цэрэндагва нарын, УБ хот, 2011
14. Хүний биеийн анатоми, Д. Амгаланбаатар нарын, УБ хот, 2012
15. Хүний физиологи Г. Дашзэвэг, Г. Батмөнх нарын УБ хот: 2011
16. Анагаахын иж бүрэн гарын авлага, Их Британийн АҮХ, Доктор Майкл Питэрс, 2016
17. Эмийн лавлах, YII хэвлэл, М. Чүлтэмсүрэн, Ч. Ерөөлт, Л. Хүрэлбаатар, УБ хот, 2015
18. Fundamentals of Nursing, 9th edition, Petter Patrica, Stockert Patrica, 2017, USA.
19. Injection safety and safe injection practices, Advanced Infection Prevention and Control (IPC) Training, WHO, 2018
20. Vincent E. Omorogbe, Vivian O. Omuemu, Alphonsus R. Isara, Injection safety practices among nursing staff of mission hospitals in Benin City, Nigeria, Annals of African Medicine Vol. 11, No. 1; 2012